



Премиум Нэксус ХК

2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ, ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

- > Холбоо барих:
- > И-мэйл: investor@cumongol.mn

ТАНЫ СОНОРТ

Таны сонорт хүргэж буй энэхүү мэдэгдэл нь Премиум Нэксус ХК-ийн гаргасан Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ) тайлангийн хамрах хүрээ, хязгаарлалтыг тодруулах зорилготой юм. БОНЗ-ын тайлан нь бизнесийн оролцогч талуудын тогтвортой байдал, ёс зүйн практикийн төлөв байдлыг илэрхийлсэн байгаль орчин, нийгэм, засаглалын хүчин зүйлсийн хүрээнд хэрэгжүүлж буй компанийн хүчин чармайлт, гүйцэтгэл, санаачилгын талаарх мэдээллийг агуулах боловч дараах зүйлсийг болгоон үзнэ үү.

1. Тайлангийн ерөнхий шинж чанар: Тус тайлан нь зөвхөн мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн бөгөөд санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын зөвлөгөө биш бөгөөд БОНЗ үзүүлэлтүүдийг өмнөх онуудтай харьцуулсан мэдээллүүдийг тусгасан юм.
2. Мэдээллийн үнэн зөв байдал: Тус тайлан нь хамгийн сүүлийн үеийн, үнэн зөв мэдээллүүдийг агуулахыг зорьж байгаа ч энэ нь тодорхой таамаглал, тооцоолол, төсөөлөл, хэтийн төлөвийг агуулсан байж болно.
3. Хязгаарлагдмал хамрах хүрээ: Тус тайлан нь тодорхой БОНЗ-ын холбогдолтой үйл ажиллагаа дээр төвлөрсөн тул байгууллагын бүхий л үйл ажиллагааг тус тайлангаар дүгнэх боломжгүй болно.
4. Гадаад хүчин зүйлс: Байгууллагын БОНЗ-ын гүйцэтгэлд зохицуулалтын өөрчлөлт, зах зээлийн нөхцөл байдал, олон улсын хэмжээний үйл явдлууд зэрэг олон гадаад хүчин зүйлс нөлөөлөх боломжтой ба тус тайлан нь эдгээр хүчин зүйлсийн БОНЗ-ын гүйцэтгэлд үзүүлэх нөлөөг бүрэн судалж тусгаагүй байх магадлалтай юм.
5. Ирээдүйн гүйцэтгэл: Тус БОНЗ-ын тайланд байгууллагын ирээдүйн БОНЗ-ын зорилго, зорилт, эрмэлзлийн талаар агуулж болох ба эдгээр нь ирээдүйн БОНЗ-ын гүйцэтгэл, үр дүнгийн баталгаа биш болно.
6. Хэрэглээ ба хариуцлага: Бид БОНЗ-ын тайлангийн үнэн зөв байдлыг хангахын тулд хүчин чармайлт гарган ажиллаж байгаа хэдий ч тайлантай холбогдох аливаа алдаа, орхигдол, үл нийцэлтэй тооцоолол болон түүний агуулгад үндэслэн хийсэн аливаа үйл ажиллагааны төлөө хариуцлага хүлээхгүй болно.

Мөн тус тайланг боловсруулахад цаг хугацааны боломжгүйгээс дараах хязгаарлагдмал байдлууд үүссэн: материаллаг нөлөөллийн үнэлгээ, өгөгдлийг нягтлах, оролцогч талуудаас мэдээлэл цуглуулах, хэрэглэгчдийн судалгаа зэргийг хийх боломжгүй байсан.

Тус БОНЗ-ын тайлантай танилцах эсхүл ашигласнаар та энэхүү мэдэгдэлд дурдсан нөхцөл, хязгаарлагдмал байдлыг хүлээн зөвшөөрч байгаа болно. Хэрэв та энэхүү мэдэгдлийн аль нэг хэсгийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа бол тайланг ашиглахаас татгалзана уу.

Байгууллагын БОНЗ-ын үйл ажиллагаа болон энэхүү мэдэгдлийн талаар нэмэлт мэдээлэл, тодруулга авахыг хүсвэл info@sumongol.mn хаягаар холбогдоно уу.

МЭНДЧИЛГЭЭ

Эрхэм хөрөнгө оруулагч, бизнесийн түншүүдээ

Премиум Нэксус ХК-ийн 2025 оны Байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын тайланг танилцуулж байгаадаа таатай байна.

2025 он манай компанийн хувьд бизнесийн өсөлтийг тогтвортой хөгжлийн зарчимтай уялдуулан хэрэгжүүлэх, засаглалын тогтолцоогоо бэхжүүлэх, оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох чиглэлд бодит ахиц гаргасан онцлох жил байлаа. Бид үйл ажиллагааны цар хүрээгээ тэлэхийн зэрэгцээ энэхүү өсөлтийг хариуцлагатайгаар удирдах, нийгэм болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллөө системтэйгээр үнэлэх, сайжруулахад анхаарлаа төвлөрүүлэн ажиллав.

Бид жижиглэн худалдааны сүлжээгээ өргөжүүлж шинээр 100 дэлгүүр өлгийдөн авч нийт 545н. дэлгүүртэй болж, өдөр тутамдаа 200,000 гаруй хэрэглэгчдэд хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг хүртээмжтэй хүргэж жилдээ 72 сая гаруй хүнд үйлчилсэн байна. Үүний зэрэгцээ бид нийлүүлэлтийн сүлжээ, логистикийн системийн үр ашгийг сайжруулах замаар нөөцийн ашиглалтыг оновчтой болгох, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлд бодит алхмуудыг хэрэгжүүлж эхэллээ. Мөн 800 гаруй шинэ ажлын байр бий болгож нийт 5145-н ажилчидтай болж, бизнес эрхлэгчдийг дэмжих, ялангуяа франчайз загвараар дамжуулан жижиг, дунд бизнесийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарч, хүнсний аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарын хяналтыг тасралтгүй сайжруулж, хэрэглэгчдийн итгэлийг хадгалах нь бидний тэргүүлэх зорилт хэвээр байсаар байна. Үүний зэрэгцээ ил тод байдал, хариуцлагыг бэхжүүлэх, ТҮЗ-ийн хараат бус байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн удирдлагыг сайжруулах чиглэлд ахиц гаргалаа. Түүнчлэн БОНЗ зарчмуудыг компанийн стратеги, шийдвэр гаргалт, хөрөнгө оруулалтын бодлогод үе шаттайгаар нэгтгэх ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлсэн үе байлаа.

Үүний зэрэгцээ тогтвортой хөгжлийн 17-н зорилтын 15-д нь өөрийн хувь нэмрээ шууд оруулж байгааг мэдэгдэхэд таатай байна.

Бид цаашид бизнесийн өсөлт болон тогтвортой хөгжлийг үргэлж харилцан уялдаатайгаар авч үзэж, бүх оролцогч талуудад урт хугацааны, тогтвортой үнэ цэнийг бий болгохыг зорин ажиллах болно. Энэ хүрээнд БОНЗ удирдлагын тогтолцоог улам боловсронгуй болгож, хэмжигдэхүйц зорилтууд, ил тод тайлагналд тулгуурласан хариуцлагатай менежментийг бэхжүүлнэ.

Манай компанийн хөгжил, амжилтад үнэтэй хувь нэмэр оруулж буй нийт ажилтан, хэрэглэгчид, түншүүд, нийлүүлэгчид болон хөрөнгө оруулагчид та бүхэнд талархал илэрхийлье.

Хүндэтгэсэн,
Эрдэнэчимэг Өлзийсүрэн
ТҮЗ-ийн Хараат бус гишүүн, ТҮЗ-ийн дэргэдэх БОНЗ хорооны дарга



Агуулга

Компанийн тухай

- 06 Түүхэн замнал
- 08 Премиум Нэксус “ЭКОСИСТЕМ”
- 09 Компанийн удирдлага
- 10 Компанийн бизнес бүтэц
- 11 Алсын хараа, эрхэм зорилго
- 12 Нийгмийн өдөр тутмын салшгүй дэд бүтэц
- 14 Стратегийн зорилтууд
- 16 Дэд бүтэц

Тогтвортой хөгжил

- 20 Тайлагнал
- 21 Тогтвортой хөгжлийн, бодлого, стратеги
- 22 БОНЗ материаллаг байдлын үнэлгээ

Байгаль орчин

- 25 Эрчим хүч
- 27 Тээвэр зохицуулалт
- 28 ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ
- 30 Хаягдлын менежмент
- 32 Байгаль орчин

Нийгэм

- 35 Нийгэм
- 45 2025 оны амжилт
- 50 Хүнсний аюулгүй байдал
- 56 ХАБЭА сургалт

Засаглал


- 59 Компанийн засаглалын кодекс
- 60 Хувьцаа эзэмшигчид
- 61 Төлөөлөн удирдах зөвлөл
- 65 ТҮЗ-ийн дэргэдэх хороод
- 67 ТҮЗ-ийн хурлын үйл ажиллагаа
- 68 ТХЗ-тод оруулж буй хувь нэмэр

Хавсралт

- 71 Хавсралт



КОМПАНИЙН ТУХАЙ



Түүхэн замнал

2015



- Монголын анхны дэлгүүрийн сүлжээ Сэнтрал Экспресс анх гурван байршилтай нээгдэв.

2017



- Сэнтрал Экспресс Си Ви Эс ХХК байгуулагдав.

2018



- Өмнөд Солонгосын BGF Retail Co.,Ltd.-тэй мастер франчайзингийн гэрээ байгуулж, CU брэндийн франчайзингийн эрхийг авсан.
- Монгол Улсын анхны "Минимаркет"-ын MNS гэрчилгээг авсан.

2019



- Нэг жилийн дотор CU брэнд 50 дэлгүүрийн байршилд хүрээгээ тэлэв.
- CU үнэнч хэрэглэгчийн хөтөлбөрийг эхлүүлж, CU мобайл аппликейшнийг нэвтрүүлэв.

2020



- Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр 97-р байранд орж, анх удаа сонгогдов.
- Монголд 100 салбар дэлгүүртэй анхны сүлжээ болов.
- Олон улсын GMP, HACCP стандартыг хангасан Монгол дахь анхны олон нийтийн хүнсний үйлдвэр ашиглалтад орлоо.
- CU брэндийн франчайзийн хөтөлбөрийг албан ёсоор эхлүүллээ.

2021



- Хүйтэн хэлхээний түгээлтийн төвийг ашиглалтад орууллаа.
- CU брэнд амжилттай IPO хийлээ.

2022



- Сэнтрал Экспресс Си Ви Эс нь Сиркл Чейн ХХК-аас Circle K 12 салбар дэлгүүрийг худалдан авах гэрээнд гарын үсэг зурж, эцэслэн байгууллаа.
- CU сүлжээ дэлгүүрийн өдрийн борлуулалт нэг тэрбум төгрөгт хүрсэн байна.
- 200 салбар дэлгүүртэй Монголын анхны сүлжээ болсон.
- 39-р байранд орж, хоёр дахь удаагаа ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарлаа.
- Өмнөд Солонгосын системийг дотооддоо шингээж, сүлжээгээр мэдээллийн технологийн нэгдсэн системийг боловсруулж хэрэгжүүлсэн.
- Хөдөө орон нутагт CU-ийн анхны салбар дэлгүүр нээгдэв.

Түүхэн замнал

2023



- > 11-р байранд орж, ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр гурав дахь удаагаа шалгарав.
- > Монголд 300 салбар дэлгүүртэй анхны сүлжээ болов.
- > Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүх “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний кампанит ажлын хүрээнд хүнсний үйлдвэрт зочиллоо.

2024



- > Үйл ажиллагааны ашгийг бий болгосон.
- > 8-р байранд орж, ТОП 100 аж ахуйн нэгжийн нэгээр дөрөв дэх удаагаа шалгарав.
- > Монголд 400 салбар дэлгүүртэй анхны сүлжээ болов.

2025



- > 500 дахь салбараа Төв аймгийн Цонжинболдогт нээлээ.
- > Монголын Хөрөнгийн Бирж дэх бүртгэл II ангиллаас I ангилал руу шилжсэн.
- > 2025 оны RETAIL ASIA AWARDS-аас “Convenience store of the year - Mongolia” шагнал хүртсэн.
- > Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн 7-р байранд шалгарсан.

Премиум Нэксус ЭКОСИСТЕМ ба түүний давуу талууд

Олон улсын стандартад нийцсэн хоол

Хоолны бүтээгдэхүүний гинжин хэлхээний бүх үе шатанд олон улсын стандарт, шилдэг туршлагад суурилсан хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд үндэсний үйлдвэрлэгчид НАССР баталгаажуулалтад хамрагдаж, салбарын стандартыг шинэ түвшинд хүргэн, зах зээлд манлайлах боломж бүрдэж байна.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг:

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг арилгах болно.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол:

CU сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ:

CU сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид энэхүү эко-системд нэгдсэнээр, Премиум Нэксусийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ийн практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж:

CU сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж:

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

Компанийн удирдлага



Компанийн бизнесийн бүтэц



Премиум Нэксус ХК



Чингис Шар Айраг
ХХК

74.59%



Сэнтрал Коммерс
ХХК

74.59%



Премиум Коммерс
ХХК

100%



Стора Централ
ХХК

100%



Сэнтрал Кофе
Рөүстинг ХХК

90.91%



Премиум Юнайтэд
ХХК

100%



Чингис Шар Айраг
Клуб ХХК

74.59%



Сэнтрал Фүүдс
ХХК

100%

CU конвниенс дэлгүүрийн алсын хараа, эрхэм зорилго




Эрхэм зорилго

Дэлхийн стандартын үйлчилгээгээр хүмүүсийн өдөр тутмын амьдралыг хялбаршуулна



Алсын хараа

Үйлчилгээгээрээ дэлхийд танигдана



Үнэт зүйл, бизнесийн үзэл баримтлал

- > Амжилт гаргагч
- > Өсөх сэтгэлгээтэй
- > Үйлчлүүлэгч төвтэй шилдэг хамтрагч

Нийгмийн өдөр тутмын салшгүй дэд бүтэц

CU нь зөвхөн бүтээгдэхүүн борлуулах цэг бус, харин хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралыг хөнгөвчилж, хэрэгцээ бүрийг нэг дор, хамгийн ойр, хамгийн шуурхай шийдэх дэд бүтэц юм.

Манай 545 конвениенс дэлгүүр нь хэрэглэгчдэд газар зүйн хувьд хамгийн ойр байрлаж, 24/7 тасралтгүй ажиллан, өдөр тутмын хэрэгцээт бүтээгдэхүүн, үйлчилгээг тогтмол, найдвартай хүргэж байна. Ингэснээр CU нь хэрэглэгчдийн амьдралын хэвшилд нэвтэрч, нийгмийн өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болон төлөвшиж байна.

Бид хэрэглэгчдэд бүтээгдэхүүн, үйлчилгээг тасралтгүй, найдвартай хүргэхийн зэрэгцээ тэдний сэтгэл ханамжийг дээд түвшинд хадгалахын тулд нийлүүлэлтийн сүлжээ, логистик, технологийн цогц шийдлүүдийг тасралтгүй хөгжүүлэн, хэрэглэгчдэд хэрэгтэй бүхий л үйлчилгээг бий болгоход анхаарч байна.



Стратегийн зорилтууд

Зах зээлд манлайлах

Зах зээлийн тэлэлт

Улаанбаатар хот

24 цагийн үйлчилгээг хэрэглэгчдэд илүү ойртуулах зорилгоор 2025 онд Улаанбаатар хотод шинээр 47 дэлгүүрүүдийг нээсэн. Улмаар Улаанбаатар хот дахь нийт хэрэглэгчдийн тоо 15.6%-иар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Орон нутаг

Орон нутагт олон улсын үйлчилгээний стандартыг нэвтрүүлж, хүнсний аюулгүй байдлыг дээшлүүлэхээс гадна аялал жуулчлалын үйлчилгээний дэд бүтцийг сайжруулах, шинээр ажлын байр бий болгох, орон нутгийн бизнес эрхлэгчдийг дэмжих, эрүүл ахуй, орчны аюулгүй байдлыг сайжруулах зэрэг олон эерэг нөлөөг орон нутгийн хөгжилд авчирч байна.

2025 онд бид 16 бүс нутагт үйл ажиллагаагаа өргөтгөж, нийт 53 дэлгүүр шинээр нээн, сүлжээний хамрах хүрээгээ мэдэгдэхүйц нэмэгдүүллээ. Энэхүү өргөтгөл нь манай брэндийн орон нутгийн зах зээл дэх цар хүрээ төдийгүй борлуулалтын боломжийг нэмэгдүүлж, ирээдүйн өсөлтийн суурийг бэхжүүлнэ.

Бид ирээдүйд манлайлагч байр сууриа хадгалж, салбарын хөгжил, зах зээлд тэргүүлэх үүргээ үргэлжлүүлэн биелүүлэхээр зорьж байна.

Хэрэглэгчдийн тоо

(Мянга)	2024	2025	Өсөлт
Улаанбаатар хот	54,212	62,716	15.6%
Орон нутаг	4,529	8,747	93.1%
Нийт	58,741	71,463	21.6%

Дэлгүүрийн тоо

	2024	2025	Өсөлт
Улаанбаатар хот	396	443	11.8%
Орон нутаг	49	102	108.1%
Нийт	445	545	22.5%

Стратегийн зорилтууд

Зах зээлд манлайлах


Франчайз бизнесийн үйл ажиллагаа

2020 оноос хувийн бизнестэй болох хүсэлтэй иргэд болон бизнесийн цар хүрээгээ тэлэх сонирхолтой жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулсан CU франчайз хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэв. Уг хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа нь тогтворжиж, хэрэглэгчдэд танигдсан дэлгүүрүүдээс сонголт хийж, өөрийн бизнестэй болох боломжийг нээснээр CU франчайз эрх эзэмшигчдийн тоо жилээс жилд тогтвортойгоор өсөж байна.

2023 оноос Зээлийн батлан даалтын сан, Капитрон банктай хамтын ажиллагааг эхлүүлэн эмэгтэйчүүдийн бизнесийн салбар дахь оролцоог нэмэгдүүлэх зорилгод нийцүүлэн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан батлан даалттай бизнесийн зээлийг жилийн 8.88%-ийн хүүтэйгээр авах боломжийг нээсэн.

2024 оноос хөдөө, орон нутгийн зах зээлд франчайз эрхээр салбаруудыг үе шаттайгаар нээн өргөжүүлж, орон нутгийн бизнес эрхлэгчдэд тогтвортой, ашигтай бизнес эрхлэх боломжийг олгон, шинэ ажлын байр бий болгох замаар бүс нутгийн эдийн засгийн хөгжилд бодитой хувь нэмэр оруулан ажиллаж байна.

2025 оны байдлаар нийт франчайз дэлгүүрийн тоо 76-д хүрч, Компанийн сүлжээний цар хүрээ тогтвортойгоор өргөжин тэлж байна.




Нийт франчайз дэлгүүр

Улаанбаатар хот дахь франчайз дэлгүүр: **71**
Хөдөө орон нутаг дахь франчайз дэлгүүр: **5**



Нийт франчайз эрх хүлээн авагч

Хоёр дэлгүүртэй эрх хүлээн авагч: **8**
Гурван дэлгүүртэй эрх хүлээн авагч: **2**



Амжилттай зээлийн хүсэлт

Эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор гуравдагч байгууллагуудтай хамтарсан зээлийн бүтээгдэхүүнийг зах зээлд амжилттай нэвтрүүлж, эмэгтэйчүүдийн бизнес эрхлэлтийг бодитоор дэмжин ажиллаж байна.

Франчайз дэлгүүрийн түүхэн өсөлт

	2023	2024	2025
Улаанбаатар хот	47	70	71
Орон нутаг	0	3	5
Нийт	47	73	76

Стратегийн зорилтууд

Зах зээлд манлайлах

Дэлгүүрийн өнгө төрхийн сайжруулалт

Хэрэглэгчдэд илүү тав тухтай, аюулгүй орчныг бүрдүүлэх, дэлгүүрийн өнгө төрхийг сайжруулах зорилгын хүрээнд, шинэ дэлгүүрүүдийн шалны материалыг халтирахаас хамгаалсан матт гадаргуутай орчин үеийн хэв маягийг шингээсэн дулаан саарал өнгийг сонгож, хана болон таазны материалын чанар хийцийг сайжруулах, заалны гэрэлтүүлгийн насжилт болон тусгалын чанарыг сайжруулах, дэлгүүрийн тавилга тохижилтын дизайныг шинэчлэн минимал загвартай болгох, харилцагчийн үрсгалыг тооцоолон зөв төлөвлөлтийн шийдлийг гаргаснаар дэлгүүр илүү цэлгэр, цэвэрхэн цэгцтэй болж чадсан. Уг шинэчлэн сайжруулалтыг хуучин дэлгүүрийн үрсгал засварын ажилд мөн адил хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийслэлийн болон орон нутгийн хэрэглэгчдийн гэнэтийн хэрэгцээ, шаардлагыг хангах, дэлгүүрт илүү тав тухтай үйлчлүүлэх зорилгоор 24 цагийн турш орох боломжтой орчин үеийн минимал хэв маягийн интерьер дизайны шийдэлтэй, дэлхийд тэргүүлэх ариун цэврийн өрөөний томоохон брэндийн тоноглолыг ашиглан цэвэр усны хэрэглээг 30-70% хүртэл хэмнэх, эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй, олон улсын жишигт нийцсэн ариун цэврийн өрөөг салбар дэлгүүрүүдэд төлөвлөж өгсөн.



Стратегийн зорилтууд

Дэд бүтэц

Нийлүүлэлтийн үнэ цэнийн хэлхээ

Нэгдсэн түгээлтийн төв нь CU конвинеенс дэлгүүрийн дэд бүтцийн чухал хэсэг бөгөөд салбар дэлгүүрт борлуулагдаж буй нийт бүтээгдэхүүний 99.9% нь нэгдсэн түгээлтийн төвөөр дамжин хүргэгддэг. Эрүүл ахуйн өндөр хяналтын дор бүтээгдэхүүнүүдийг салбар дэлгүүрийн захиалгын дагуу бэлтгэж түгээлт, хүргэлтийн тусгай зориулалтын өөрсдийн тээврийн хэрэгслээр салбар дэлгүүрүүдэд хүргэдэг. Хөлдөөсөн бүтээгдэхүүн, зайрмаг гэх мэт эмзэг, температурын нарийн горимд түгээгдэх шаардлагатай савласан бүтээгдэхүүнүүдийг хүйтэн түгээлтийн төвд төвлөрүүлж, мөн хөргөх болон хөлдөөх зориулалттай төхөөрөмжөөр тоноглогдсон тусгай тээврийн хэрэгслээр салбар дэлгүүрүүдэд түгээж байна.



Анализ, төлөвлөлт



Агуулах, дүүргэлт




Захиалга хүргэлт



Хүргэлт



Дэлгүүр хүлээн авах



Стратегийн зорилтууд

Дэд бүтэц

Логистикийн цогц шийдэл

Хүнсний бүтээгдэхүүний агуулахын стандарт шаардлагыг бүрэн хангаж, температурын горимын ялгаатай байдлыг оновчтой шийдсэн нэгдсэн түгээлтийн төвүүд буюу хуурай түгээлтийн төв, хүйтэн хэлхээ агуулах, зориулалтын тусгай горим бүхий температураа барих технологитой тээврийн хэрэгслүүдээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Хуурай түгээлтийн төв

Хуурай түгээлтийн төв нь 2025 онд 99.3% гүйцэтгэлтэйгээр бүтээгдэхүүн бэлтгэн гаргасан ба энэ нь өмнөх онтой харьцуулахад 22%-иар нэмэгдсэн ачааллыг даван туулсан үзүүлэлт юм. Гүйцэтгэлээ нэмэгдүүлэхэд А, Б түгээлтийн төвийг холбосон байгууламжийг барьж, бараа материалыг хоёр чиглэлд урсгах конвейрийн хөрөнгө оруулалт хийснээр бүтээмжийг нэмэгдүүлж, ажиллах цагийг бууруулах давуу талыг бий болгосон.


Хүйтэн түгээлтийн төв

Хүйтэн түгээлтийн төв нь хоёр ээлжээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд оргил ачааллын үед хөлдүү бүтээгдэхүүний захиалгыг хугацаанд нь бэлтгэх зорилгоор нэмэлт хөлдүү агуулах түрээслэх, захиалгыг нэг хоногийн өмнө бэлтгэх зэрэг арга хэмжээ авснаар нийт захиалгын гүйцэтгэл 99.98% болсон амжилттай үр дүнд хүрсэн.

Хуурай түгээлтийн төв



Хүйтэн түгээлтийн төв




Стратегийн зорилтууд

Дэд бүтэц


Нэгдсэн түгээлтийн систем

- Тээврийн үйл ажиллагааны хувьд Улаанбаатар хот дахь нийт салбарын түгээлтийг өөрсдийн тээврийн хэрэгслээр бүрэн зохион байгуулж эхэлсэн бөгөөд орон нутгийн түгээлтийг өөрсдийн бүрэн хяналт дор туслан гүйцэтгэгчидтэй хамтран түгээлт хийж байна.
- Өөрсдийн тээврийн хэрэгслийн давуу байдлыг бий болгосны хүрээнд хөлдүү болон хөргүүрийн бүтээгдэхүүнийг бүхээгийн хуваалтын тоног ашиглан нэгэн зэрэг түгээж эхэлсэн нь авто замын ачаалалд тодорхой хэмжээнд нөлөөлж чадсанаас гадна дотоод зардлын үр ашиг гаргасан давуу талтай байна.
- Түүнчлэн хуурай болон хөргүүртэй агуулахаас нэгдсэн түгээлтийн системтээр дамжуулан нийт салбар дэлгүүрийн захиалгын 85 орчим хувийн түгээлтийг замын хөдөлгөөний ачааллын бус цаг болох орой 22 цагаас өглөө 7 цаг хүртэл хийж гүйцэтгэснээр нийт түгээлт хийх авто машины хэрэгцээг 10 дахин бууруулж чадсан байна.
- Өөрсдийн тээврийн хэрэгслийн цэвэрлэгээ үйлчилгээ болон хуваарьт засварын ажлыг бүрэн зохион байгуулах хүчин чадалтай Авто засварын цехийг ашиглалтад оруулан ажиллаж байна.

Цэгээс цэгт хийх түгээлт



Нэгдсэн түгээлтийн систем



ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ



Тайлагнал

Премиум Нэксус ХК нь Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам”-ын дагуу өөрийн бизнесийн үйл ажиллагааны БОНЗ-ын үзүүлэлт, үр нөлөөг дөрөв дэх жилдээ сайн дурын үндсэн дээр хувьцаа эзэмшигчид, хөрөнгө оруулагчид, харилцагч байгууллагууд болон олон нийтэд ил тод, нээлттэйгээр тайлагнаж байна.

Бүтээгдэхүүн удирдлагын үйл ажиллагаа

Тайланг боловсруулахдаа Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын тогтвортой санхүүгийн холбоо (ТоС Холбоо), Олон улсын санхүүгийн корпораци (ОУСК), НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Европын Холбооны Тогтвортой байдлын тайлагналын стандарт, Азийн Хөгжлийн банк (АХБ), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)-ны Байгаль орчин, нийгмийн дью дилиженсийн шаардлага, Монголын Хөрөнгийн Биржийн “Байгаль орчин, нийгэм, засаглал ба тогтвортой байдлын тайлагналын удирдамж” болон бусад олон улсын холбогдох стандарт, удирдамжуудыг мөрдөж ажиллалаа.

Тогтвортой байдлын удирдлагын тогтолцоо	Байгаль орчин	Нийгэм	Засаглал	Салбарын нэмэлт үзүүлэлт
Удирдлагын менежмент, амлалт	Эрчим хүч	Хүний нөөцийн хөгжил	Компанийн засаглал	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрлэл
Тогтвортой байдлын бодлого зохицуулалт	Хүлэмжийн хийн ялгарал	Хөдөлмөрийн аюулгүй байдал	Авлига, ёс зүй	Боловсруулах үйлдвэрлэл
Удирдлагын бүтэц	Уур амьсгалын өөрчлөлт	Эрх тэгш байдал	Комплаенс, хууль дүрмийн мөрдөлт	
Тогтвортой хөгжлийн нөлөөллийн үнэлгээ	Ус	Хүртээмжтэй тэгш оролцоо	Оролцогч талуудын оролцоо	
Чадавх бүрдүүлэлт	Хог хаягдал	Нийгмийн хариуцлага, ил тод байдал		
Хяналт шинжилгээ	Биологийн олон янз байдал	Тогтвортой ханган нийлүүлэлтийн сүлжээний удирдлага		
Тогтвортой байдлын тайлагнал, баталгаажуулалт				
Гишүүнчлэл				

Тогтвортой хөгжлийн, бодлого, стратеги

Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны 07-р сарын 04-ны өдрийн 26-р тоот тогтоолоор “Хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын бодлого”-ыг батлан тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлон, хэрэгжилтийг хангасан журмын зохицуулалт хийгдсэн. Мөн байгууллагын удирдлагын зүгээс тогтвортой хөгжлийн чиглэлд өгч буй анхаарал зэргийг үндэслэн байгууллагын цаашдын бодлого, стратегид тогтвортой хөгжлийн асуудлуудыг үндсэн асуудлуудын нэгээр тодорхойлж, холбогдох бодлогын баримт бичгийг боловсруулж, удирдлагын түвшинд манлайлал үзүүлэн ажиллаж, компанийн ёс зүйн дүрмийг шинэчлэн шүгэл үлээх үйл ажиллагааны журам, гомдол хүлээж авах, барагдуулах журмыг боловсруулан, хэрэгжүүлж байна. Үйл ажиллагааны зорилго, зорилтоо тогтвортой хөгжлийн 17 зорилготой уялдуулан тодорхойлон төлөвлөж, хэрэгжилтийг ханган үр дүнг бүх оролцогч талуудад нээлттэй, ил тодоор тайлагнах үйл явц төлөвшин жигдэрч байна.



Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа

Тогтвортой хөгжлийн сургалтын нэгдсэн хөтөлбөр гараагүй боловч хөдөлмөрийн харилцаа, ХАБЭА, байгаль орчин, бэлтгэн нийлүүлэлтийн тогтвортой байдал чиглэлээр сэдэвчилсэн сургалтууд хийгдсэн. Мэдээллүүд нь холбогдох хэсэгт орсон болно.

Хяналт

ТУЗ-ийн дэргэдэх “БОНЗ-ын хороо” нь компанийн БОНЗ-тай холбоотой бодлого, стратеги болон дүрэм журмыг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих, дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааг хянан нягтлах үүрэгтэй ажилладаг.

Тайлагнал ба баталгаажуулалт

Премиум Нэксус ХК нь 2021 оноос эхлэн (олон нийтэд нээлттэй хувьцаат компани болохоосоо өмнө) БОНЗ-ын тайланг боловсруулж, хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулж, олон нийтэд нээлттэй байршуулж байна.


Гишүүнчлэл, хамтын ажиллагаа

Монголын худалдаа аж үйлдвэрийн танхимтай хамтран ажилладаг. НҮБ-н Бизнес ба Хүний Эрхийн чиглэлээр баримтлах зарчмыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд төр болон олон улсын байгууллагаас хөхиүлэн дэмжиж буйд хамтын чармайлтаар Тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг биелүүлэхэд идэвхтэй оролцож байна.

БОНЗ материаллаг байдлын үнэлгээ

№	Код	Эрсдэлт хүчин зүйлс	Зорилт
1	Б1	Хүлэмжийн хийн ялгарал	Үйл ажиллагаанаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлын Хүрээ 1 (өөрийн үйл ажиллагаанаас) ба Хүрээ 2 (эрчим хүчний хэрэглээнээс шууд эсвэл дам) -нд зорилго дэвшүүлж, бууруулах арга хэмжээ авах.
2	Б2	Хог хаягдал	Үйл ажиллагаанаас үүсэж буй хатуу болон шингэн хог хаягдлын зохистой менежментийг хэрэгжүүлэхийг зорих.
3	Б3	Эрчим хүчний хэрэглээ	Цахилгаан, дулааны хэмнэлттэй технологи, тоолуурыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, сурталчлах замаар уур амьсгалын өөрчлөлтийг хязгаарлахад хувь нэмэр оруулахыг зорих.
4	Б4	Усны хэрэглээ	Ахуй, ундны усыг ариг гамтай хэрэглэх, тоолууржуулах, ус алдагдлыг багасгах санаачилга, соён гэгээрүүлэх арга хэмжээ авч ажиллах.
5	Н1	Хүний эрх	Хүний эрхийг хүндэтгэсэн, хариуцлагатай, хүртээмжтэй, ая тухтай үйлчилгээг эрхэмлэн хүний эрхийн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчил үүссэн бол түүнийг бууруулах, арилгах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх цогц тогтолцоог хэрэгжүүлэх.
6	Н2	Нийгмийн хариуцлага	Нийгмийн салшгүй нэг хэсэг гэдгээ хүлээн зөвшөөрч хүн ба байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа эрхлэхийг чармайх.
7	Н3	Хөдөлмөрийн харилцаа	Ажилтан бүрд хөдөлмөрөө шударгаар үнэлүүлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, эвлэлдэн нэгдэх, сүрч хөгжих боломжийг олгох.
8	Н4	Хүнсний аюулгүй байдал	Хүнсний эрүүл ахуй, аюулгүй байдал, хяналтын тогтолцоог төлөвшүүлэн ажиллах.
9	Н5	ХАБЭА	Ажилтны эрүүл мэндийг хамгаалах, эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөл бүхий хүнд ээлтэй ажлыг байрны соёлыг хэвшүүлэх.
10	Н6	Тогтвортой худалдан авалт	Тогтвортой (ногоон) ханган нийлүүлэгчийн бодлогоор дамжуулж харилцагч, нийлүүлэгчдэд үйл ажиллагаандаа хаягдлыг бууруулах, хүний эрхийг дээдэлсэн хариуцлагатай нөөцийг зохистой ашиглаж, орон нутгийн бизнесийг дэмжин хөгжүүлэх, хүнд ээлтэй ажлыг байр бүрдүүлэх чиглэлээр нөлөөлөн хамтран ажиллах.
11	31	Ёс зүй	Бизнесийн ёс зүйн зарчмыг чандлан сахих.
12	32	Бизнесийн тасралтгүй байдал	Болзошгүй өөрчлөлт, хямралын эрсдэл, үр дагаврыг урьдчилан үнэлж, төлөвлөж, хэрэгжүүлэх замаар бизнесийн тасралтгүй үйл ажиллагааг хангах.
13	33	Мэдээллийн аюулг	Мэдээллийн хоёр чиглэлийн урсгалыг эрхэмлэн, бизнесийн үйл ажиллагааны тайлан, мэдээг нээлттэй ил тодоор оролцогч талуудад хүргэх.
14	34	Ялгаатай байдал, Тэгш боломж, Оролцоо	Байгууллагын менежментийн бүх шатанд жендерийн эрх тэгш байдлыг ханган ажиллахыг чармайх.
15	35	Мэдээллийн аюулгүй байдал	Мэдээллийн нууцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах замаар мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх.


БАЙГАЛЬ ОРЧИН



ЭРЧИМ ХҮЧ

Премиум Нэксус ХК нь хоол үйлдвэрлэлийн төв, нэгдсэн агуулах, шар айраг болон кофе үйлдвэрлэл, түгээлтийн төв, оффисын барилгууд болон хот, хөдөөгийн 545 орчим салбар дэлгүүрт үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр объектуудын ихэнх нь суурьшлын бүсэд байрладаг бөгөөд цахилгаан эрчим хүчийг төвлөрсөн сүлжээнээс хангуулж, гэрээний дагуу 10,791,038,632 төгрөгийн төлбөрийг тайлант хугацаанд хугацаанд нь бүрэн төлсөн байна. Харин цөөн тооны орон нутгийн дэлгүүрүүдийн хувьд дизель эх үүсвэртэй байдаг.

Эрчим хүчний хэрэглээ (компаниар)



Компанийн 2025 онд батлагдсан Хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, дахин боловсруулах, дахин ашиглах үүднээс Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулж, хог хаягдлын менежментийг тээвэрлэлтээс эхлэн “Урбан солид вэйст менежмент” ХХК-тай компани өөрөө хийж гүйцэтгэж байна.

Дээрх хугацаанд БГД-ийн 71 салбар дэлгүүр мөн түгээлтийн төвөөс нийт 618 реэйсээр нийт 608.3тн хог хаягдлыг тээвэрлэсэн ба үүнээс 50.6% буюу 307.6тн дахиврыг байгальд дарж булшлагдахаас сэргийлж эдийн засгийн эргэлтэд орох нөхцөлийг бүрдүүлэв.

2025 онд нийт 307.6 тн дахиврыг эдийн засгийн эргэлтэд оруулж дахин боловсруулж чадсан нь хүлэмжийн хийн тооцооллыг хийхэд ашиглагддаг ландфиллд хог хаягдлыг булшлахад ялгарах метан хийн ялгарлыг тооцдог (IPCC 2006/2019) консерватив коэффициент ашигласан тооцоогоор 266.2 тн CO₂e Эквивалент хүлэмжийн хийн ялгарлаас сэргийлсэн нь ойролцоогоор 12,000 модыг 1 жил тарьж ургуулсантай тэнцэх хэмжээний үр дүнг үзүүлсэн байна.

Хүнсний хог хаягдлыг компост бордоо байдлаар ашиглах туршилтын ажлыг эхлүүлсэн ба нийт дахин боловсруулах боломжтой хаягдлын хэмжээг 17%-иар нэмэгдүүлэн 67%-д хүргэх ач холбогдолтой.

Эрчим хүчний үзүүлэлтүүд	Эрчим хүчний хэрэглээ (жилээр)	Зардал, ₮
1.4: Түлшний нийт зарцуулалтын хэмжээ	219.020 тн дизель 329.17 тн сайжруулсан нүүрс 13461 л газ	11,673,137,663 ₮
1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий	329.17 тн сайжруулсан нүүрс 13461 л газ	85,018,321 ₮ 135,897,927 ₮
2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	219.020 тн дизель	661,182,783 ₮
1.5: Хүрэн буюу СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%	10,791,038,632 ₮
1.6: СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%	


ЭРЧИМШИЛ

Нэг үйлчлүүлэгчид ногдох эрчим хүчний хэрэглээ 2019 онд 1.57 кВт.ц байсан бол 2021 онд 3.69 кВт.ц хүртэл огцом өссөн бөгөөд үүнээс хойш тогтмол буурч, 2025 онд 2.02 кВт.ц болж буурсан байна. Энэ нь цар тахлын үеийн үйл ажиллагааны өөрчлөлт, хэрэглэгчийн урсгалын бууралтаас үүдэлтэй өсөлтийн дараа үйл ажиллагаа тогтворжиж, нэгж хэрэглэгчид ногдох эрчим хүчний хэрэглээ аажмаар буурч байгааг харуулж байна. Компанийн үйл ажиллагааны цар хүрээ өргөжиж, салбар дэлгүүрийн тоо болон үйлчилгээний төрөл нэмэгдсэн хэдий ч борлуулалтын орлоготой харьцуулахад эрчим хүчний хэрэглээний үр ашиг сайжирч, нэгж орлого бий болгоход зарцуулах эрчим хүчний хэмжээ буурсан нь ажиглагдаж байна.

Эрчим хүчний хэрэглээний харьцаа

Төрөл	2019	2020	2021	2022	2023	2024	2025
Нэг үйлчлүүлэгчид ногдох кв.цаг	1.57	1,76	3,69	2,61	2,32	2,29	2,02
Системийн борлуулалт / эрчим хүчний харьцаа (MNT / кв.цаг)	7,70	9,79	29,43	22,89	22,20	25,05	23,34
1 сая төгрөгийн борлуултын цахилгааны хэрэглээ кв.цаг	129.72	102.13	33.97	43.69	45.03	39.92	42.84

Сүлжээ дэлгүүрүүдийн борлуулалт ба эрчим хүчний харьцаа



Стратегийн зорилтууд

Тээвэр зохицуулалт

Түгээлтийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, байгаль орчны нөлөөллийг бууруулах зорилгоор хүргэлтийн тээврийн зохицуулалтыг оновчтой төлөвлөн хэрэгжүүлж байна.

Энэ хугацаанд хүргэлтийн үйлчилгээг өглөөний 04:00–08:00 цагийн хооронд, замын хөдөлгөөний ачаалал багатай үед зохион байгуулж, түгээлтийн үр ашгийг нэмэгдүүлсэн. Хотын зүүн бүсэд байрлах хүйтэн хэлхээний түгээлтийн төвөөр дамжуулан хөргүүртэй тээврийн хэрэгслээр өдөр бүр 80,000–100,000 нэгж хүнсний бүтээгдэхүүн, харин баруун өмнөд бүсэд байрлах ердийн түгээлтийн төвөөс энгийн ачааны машинаар өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнийг салбар дэлгүүрүүдэд тогтмол хүргэж байна.

Энэхүү тээврийн зохицуулалтын үр дүнд:

- Тээврийн хэрэгслийн давтамж, хөдөлгөөний тоог мэдэгдэхүйц бууруулсан
- Түгжрэлгүй цагт түгээлт хийснээр хүргэлтийн хугацааг 4 дахин богиносгосон
- Шатахуун зарцуулалтыг 80%-иар бууруулсан улмаар агаарын бохирдол болон хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад бодит хувь нэмэр оруулж байна.



Стратегийн зорилтууд

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ

Хүлэмжийн хийн ялгаруулалт

E 2.1: Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн. Үүнээс:	29,218,72 тн CO ₂ eq
	1-р хүрээний (Шууд)	тн CO ₂ eq
	2-р хүрээний (Шууд бус эрчим хүч)	24,218.65 тн CO ₂ eq
E 2.2: Бууруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас бууруулсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	Тооцоолох боломжгүй
E 2.3: Дүйцүүлэх арга хэмжээ / Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	Тооцоолох боломжгүй

Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх шууд ялгарал (1-р хүрээ) болон гаднаас худалдан авч буй эрчим хүчний хэрэглээнээс үүсэх шууд бус ялгарал (2-р хүрээ)-ыг боломжит өгөгдөлд үндэслэн тооцоолсон.

Харин шууд бус бусад ялгарал (3-р хүрээ)-ын хувьд шаардлагатай өгөгдөл бүрэн бүрдээгүй тул энэ удаагийн тайланд хамруулаагүй болно. Түүнчлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, хаягдлын менежменттэй холбоотой хүлэмжийн хийн ялгарал, мөн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA) хийгдээгүй байгаа нь нарийвчилсан тооцоолол хийх боломжийг хязгаарлаж байна.

Хүлэмжийн хийн ялгарлын тооцооллоос үзэхэд компанийн нийт ялгарлын дийлэнх хэсгийг гаднаас худалдан авч буй эрчим хүчний хэрэглээнээс үүсэх 2-р хүрээний ялгарал бүрдүүлж байна. Энэ нь компанийн үйл ажиллагаа цахилгаан болон дулааны хэрэглээнээс өндөр хамааралтай байгааг илтгэж байна.

Тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагаанаас үүсэх шууд ялгарал (1-р хүрээ) болон гаднаас худалдан авч буй эрчим хүчний шууд бус ялгарал (2-р хүрээ)-ыг бэлэн байгаа өгөгдөлд үндэслэн тооцоолсон. Шууд бус бусад эх үүсвэрийн ялгарлыг (3-р хүрээ) тооцоход мэдээлэл дутуу тухайлбал бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт болон хаягдал боловсруулахтай холбоотой хүлэмжийн хийн ялгарлын мэдээлэл байхгүй, мөн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA) хийгдээгүй тул нарийвчилсан тооцоо хийх боломжгүй байна.

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРЛЫГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Сүлжээ дэлгүүрийн үйл ажиллагаанд CU аппликейшнийг нэвтрүүлснээр цаасны хэрэглээг бууруулж, байгалийн нөөцийг хэмнэх, улмаар хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд компанийн хүлэмжийн хийн ялгарлын эрчимшлийг тооцоход нэг хэрэглэгчид үйлчлэхэд 1.62 кгCO₂e, харин 1,000,000 төгрөгийн борлуулалт тутамд 45.15 кгCO₂e ялгаруулж байна. Эдгээр үзүүлэлт нь компанийн үйл ажиллагааны цар хүрээ болон эрчим хүч, тээвэрлэлтийн хэрэглээтэй шүүд хамааралтай байна.

Мөн хог хаягдлыг төвлөрсөн цэг (ландфилл)-т булшлан устгахаас сэргийлэх зорилгоор дахин боловсруулах үйл ажиллагааг хэрэгжүүлж, үүнээс үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах тооцооллыг олон улсад өргөн хэрэглэгддэг IPCC (2006/2019)-ийн консерватив коэффициентод үндэслэн хийсэн. Үүний үр дүнд түгээлтийн төвөөс нийт 202.8 тонн CO₂-эквивалент хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан бөгөөд энэ нь нэг мод жилд дунджаар 20–25 кг CO₂ шингээдэг гэж тооцвол 9,000 гаруй модыг нэг жилийн хугацаанд ургуулсантай тэнцэх хэмжээний эерэг нөлөөлөл үзүүлсэн байна.

The infographic features a green banner with the text "Байгальд ээлтэй" (Eco-friendly) and a circular icon of a person with a gear. Below this, the text reads: "E-Barimt-н бүртгэлээ холбоод л худалдан авалт автоматаар бүртгэгдэж, цаас хэвлэхгүй илүү байгальд ээлтэй хэрэглэгч болно." (By registering E-Barimt through the app, you can register for purchases at the automatic terminal without paper, becoming an eco-friendly user.) At the bottom, a smartphone displays the CU Mongolia app interface, showing a registration confirmation screen with a green checkmark and the text "Түгээгч Ороогчид" (Registered User).


Хаягдлын менежмент

Усны хэрэглээ

Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	357,355м ³
Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	Тайлагнах боломжгүй
Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	0%
Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	0%

Төвлөрсөн цэвэр, бохирын системд холбогдоогүй цөөн хэдэн салбар дэлгүүрүүд хотын захаар байрлах бөгөөд зөөврийн усан хангамжаар шийдсэн байдаг. Хүнсний үйлдвэр цэвэр, бохир төвийн шугамтай холбогдсон байдаг. Хоолны үйлдвэрт ашиглагдах ус 4 төрлийн мембран фильтрээр физик, хими, микробиологийн цэвэршүүлэлт хийгдэн ашиглагддаг. Усны чанарыг Эрүүл ахуйн журмын дагуу сар, улирал бүр холбогдох байгууллагаар шинжилгээнд хамруулдаг. Үйлдвэрээс гарах хаягдал ус бохирын төвлөрсөн шугамд нийлүүлэгддэг.

УСНЫ ХЭРЭГЛЭЭ/КОМПАНИАР



Хаягдлын менежмент

Хог, хаягдлын судалгаа -2025

Хог хаягдлыг тээвэрлэдэг дүүргүүдийн ТҮК-иуд нь хог хаягдлыг тогтоосон өдөр, хуваарийн дагуу ачилт, цуглуулалт хийдэггүйгээс шалтгаалан сүлжээ дэлгүүрүүдэд хог ихээр хуримтлагддаг. Үүнийг шийдэхийн тулд Салбар дэлгүүр, хоол үйлдвэрлэл болон түгээлтийн төвүүдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, ангилан ялгасан тээвэрлэлт явуулах боломжийг судлахаар 2025 онд Нийслэлийн БГД-ийн ЗД-тай гэрээ байгуулж хаягдлын менежмент сайжруулах ажлыг эхлүүлсэн.

Нэг үйлчлүүлэгч
30гр /өдөрт
545 дэлгүүр
2,275.09тн /жил
6,233кг /өдөрт
Нэг дэлгүүрээс өдөрт үүсэх хогны хэмжээ дунджаар 13кг

Нийт хог, хаягдлын 64 хувийг дараах байдлаар дахин боловсруулах боломжтой. Үүнээс:
Дахивар түүхий эд
Хүнсний хаягдлыг компост бордоо байдлаар ашиглах

Картон цаас 26%	Гялгар уут 4%
Хүнсний хаягдал 17%	Шилэн лонх 2%
Сав баглаа боодлын хаягдал 8%	Аюултай хаягдал 2%
Ус ундааны хуванцар PET/ сав 6%	Металл сав, лааз 1%
	Бусад хаягдал 33%

БГД дэх хог хаягдлын менежмент -2025


Компанийн 2025 онд батлагдсан Хүрээлэн буй орчин, нийгмийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, дахин боловсруулах, дахин ашиглах үүднээс Нийслэлийн Баянгол дүүргийн Засаг даргын тамгын газартай гэрээ байгуулж, хог хаягдлын менежментийг тээвэрлэлтээс эхлэн “Урбан солид вэйст менежмент” ХХК-тай компани өөрөө хийж гүйцэтгэж байна.

Дээрх хугацаанд БГД-ийн 71 салбар дэлгүүр мөн түгээлтийн төвөөс нийт 618 рэйсээр нийт 608.3тн хог хаягдлыг тээвэрлэсэн ба үүнээс 50.6% буюу 307.6тн дахиврыг байгальд дарж булшлагдахаас сэргийлж эдийн засгийн эргэлтэд орох нөхцөлийг бүрдүүлэв.

2025 онд нийт 307.6 тн дахиврыг эдийн засгийн эргэлтэд оруулж дахин боловсруулж чадсан нь хүлэмжийн хийн тооцооллыг хийхэд ашиглагддаг ландфиллд хог хаягдлыг булшлахад ялгарах метан хийн ялгарлыг тооцдог (IPCC 2006/2019) консерватив коэффициент ашигласан тооцоогоор 266.2 тн CO₂e Эквивалент хүлэмжийн хийн ялгарлаас сэргийлсэн нь ойролцоогоор 12,000 модыг 1 жил тарьж ургуулсантай тэнцэх хэмжээний үр дүнг үзүүлсэн байна.

Хүнсний хог хаягдлыг компост бордоо байдлаар ашиглах түршилтын ажлыг эхлүүлсэн ба нийт дахин боловсруулах боломжтой хаягдлын хэмжээг 17%-иар нэмэгдүүлэн 67%-д хүргэх ач холбогдолтой.

Дахивар түүхий эд	
Цаас /кг/	275,334
Гялгар уут /кг/	18,251
Лааз /кг/	14,014
Ландфилд булшилсан хог	
Холимог хог /кг/	390,520




Байгаль орчин


Хог, хаягдлын менежмент -2025

Эх үүсвэр дээр ангилан ялгаж, дахин боловсруулалтыг хийснээр 2030 он гэхэд хог хаягдлаас үүсэх хүлэмжийн хийн ялгарлыг **2 дахин** бууруулах зорилт тавин ажиллаж байна.

Нүүрс хүчлийн хийн ялгарал /1метр тонн CO2/



Метан хийн ялгарал /1метр тонн CH4/



Хог, хаягдлын судалгаа -2025

Хог хаягдлыг тээвэрлэдэг дүүргүүдийн ТҮК-иуд нь хог хаягдлыг тогтоосон өдөр, хуваарийн дагуу ачилт, цуглуулалт хийдэггүйгээс шалтгаалан сүлжээ дэлгүүрүүдэд хог ихээр хуримтлагддаг. Үүнийг шийдэхийн тулд Салбар дэлгүүр, хоол үйлдвэрлэл болон түгээлтийн төвүүдэд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, ангилан ялгасан тээвэрлэлт явуулах боломжийг судлахаар 2025 онд Нийслэлийн БГД-ийн ЗД-тай гэрээ байгуулж хаягдлын менежмент сайжруулах ажлыг эхлүүлсэн.



Онцлох үйл явдлууд

БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДАЛ

Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	N/A
Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан зэрлэг ургамал, амьтдын төрөл зүйлийн тоо	N/A
Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	N/A


Өөрийн үйл ажиллагаанаас үүсэх шууд ялгарал (1-р хүрээ) болон гаднаас худалдан авч буй эрчим хүчний хэрэглээнээс үүсэх шууд бус ялгарал (2-р хүрээ)-ыг боломжит өгөгдөлд үндэслэн тооцоолсон.

Харин шууд бус бусад ялгарал (3-р хүрээ)-ын хувьд шаардлагатай өгөгдөл бүрэн бүрдээгүй тул энэ удаагийн тайланд хамруулаагүй болно. Түүнчлэн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт, хаягдлын менежменттэй холбоотой хүлэмжийн хийн ялгарал, мөн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA) хийгдээгүй байгаа нь нарийвчилсан тооцоолол хийх боломжийг хязгаарлаж байна.

Хүлэмжийн хийн ялгарлын тооцооллоос үзэхэд компанийн нийт ялгарлын дийлэнх хэсгийг гаднаас худалдан авч буй эрчим хүчний хэрэглээнээс үүсэх 2-р хүрээний ялгарал бүрдүүлж байна. Энэ нь компанийн үйл ажиллагаа цахилгаан болон дулааны хэрэглээнээс өндөр хамааралтай байгааг илтгэж байна.

Тайлант хугацаанд өөрийн үйл ажиллагаанаас үүсэх шууд ялгарал (1-р хүрээ) болон гаднаас худалдан авч буй эрчим хүчний шууд бус ялгарал (2-р хүрээ)-ыг бэлэн байгаа өгөгдөлд үндэслэн тооцоолсон. Шууд бус бусад эх үүсвэрийн ялгарлыг (3-р хүрээ) тооцоход мэдээлэл дутуу тухайлбал бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалт болон хаягдал боловсруулахтай холбоотой хүлэмжийн хийн ялгарлын мэдээлэл байхгүй, мөн бүтээгдэхүүний амьдралын мөчлөгийн үнэлгээ (LCA) хийгдээгүй тул нарийвчилсан тооцоо хийх боломжгүй байна.

НИЙГЭМ



Хүний нөөц, жендерийн эрх тэгш байдал

2025 оны байдлаар Премиум Нэксус ХК нь 100 шинэ салбар дэлгүүр нээж, нийт салбарын тоо 545-д хүрсэн бөгөөд үүнээс 443 нь Улаанбаатар хотод, 102 нь орон нутагт үйл ажиллагаа явуулж байна. Компанийн үйл ажиллагаа өргөжихийн хэрээр ажлын байрны тоо нэмэгдэж, 2025 оны байдлаар нийт ажилтны тоо 5,154-д хүрсэн байна. Үүнээс 4312 ажилтан Улаанбаатар хотод, 833 ажилтан 16 аймагт ажиллаж байна.

Орон нутаг дахь ажлын байрны тоо тогтмол өсөж байгаа нь орон нутагт тогтвортой орлоготой ажлын байр бий болгох, шилжилт хөдөлгөөнийг бууруулах, иргэдийг гэр бүлтэйгээ хамт амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд чухал нөлөө үзүүлж байна. Түүнчлэн орон нутгийн залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, чадварлаг хүний нөөцийг орон нутагт хөгжүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн төвлөрлийг сааруулахад компанийн үйл ажиллагаа бодит хувь нэмэр оруулж байна.

Салбар дэлгүүрийн тоо нэмэгдсэнээр тайлант хугацаанд нийт 803 шинэ ажлын байр бий болж, олон өрхийн амьжиргаанд эерэг нөлөө үзүүлсэн. Насны бүтцийн хувьд нийт ажилтнуудын 88 хувийг 18–34 насны залуучууд эзэлж байгаа нь залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд компанийн гүйцэтгэж буй үүргийг харуулж байна.

Премиум Нэксус ХК нь Монгол Улсад “цагийн ажил”-ын тогтолцоог нэвтрүүлэн хөгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж, залуучууд болон оюутнуудын хөдөлмөр эрхлэх уян хатан боломжийг бүрдүүлсээр байна.

Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	16%
Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	803
Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	2.7
Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Үгүй
Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-28% Эм-72%
Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-78% Эм-22%
Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-48.8% Эм-51.1%
Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-30% Эм-70%
Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	1:1

Нийгэм

Хүний нөөц ба олон талт тэгш байдал, хүртээмж

2025 оны байдлаар Премиум Нэксус ХК нь нийт 5,145 ажилтантай, үүнээс 4,312 нь Улаанбаатар хотод, 833 нь орон нутгийн 16 аймагт ажиллаж байна. Компани орон нутгийн үйл ажиллагаагаа идэвхтэй тэлж байгаа бөгөөд орон нутгийн ажилтны тоо тогтмол өсөж байна.

Орон нутгийн нутгийн ажиллах хүчийг нэмэгдүүлэх бодлого нь бодлого нь дараах зорилтуудыг хэрэгжүүлэхэд чиглэгдэнэ. Үүнд:

- Орон нутгийн иргэдийг тогтвортой орлоготой, ажлын байртай болгох. Шилжилт хөдөлгөөнийг бууруулж, гэр бүлтэйгээ хамт байх нөхцөлийг бүрдүүлэх
- Орон нутгийн залуусын хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, чадварлаг хүний нөөцийг бүс нутагт үлдээх
- Хөдөлмөрийн зах зээлийн төвлөрлийг сааруулах

Эдгээр зорилтууд нь нийгэм, эдийн засгийн хүртээмжтэй хөгжлийг дэмжих чухал алхам болж байна.

Цаашид Премиум Нэксус ХК нь орон нутгийн ажиллах хүчний бүтцийг улам өргөжүүлж, эдийн засгийн урт хугацааны эерэг нөлөө үзүүлж, хөгжлийг дэмжих стратегитай ажиллахаар зорьж байна. Үүний хүрээнд шинээр нээгдэх салбар дэлгүүрүүдэд орон нутгийн иргэдийг сургаж хөгжүүлж, тогтмол ажлын байраар хангаж, тогтвортой орлогын эх үүсвэртэй болгох бодлогыг тууштай хэрэгжүүлнэ.

Бүх нутаг	Тоо	Хувь
Улаанбаатар	4,312	83%
Архангай	51	1%
Баянхонгор	25	0.5%
Булган	28	0.5%
Говьсүмбэр	24	0.5%
Дархан	60	1.2%
Дорноговь	39	0.7%
Дорнод	37	0.7%
Дундговь	15	0.2%
Орхон	112	2.1%
Өвөрхангай	44	0.8%
Өмнөговь	59	1.1%
Сүхбаатар	19	0.4%
Сэлэнгэ	122	2.3%
Төв	102	2%
Хөвсгөл	41	1%
Хэнтий	55	1%



Хүний нөөц ба олон талт тэгш байдал, хүртээмж

Премиум Нэксус ХК нь хүний нөөцийн бодлогодоо олон талт байдал, тэгш боломж, хүртээмжтэй хөдөлмөр эрхлэлтийн зарчмыг нэн тэргүүнд баримталдаг. Компанийн ажиллах хүчний бүтцийн хувьд бүх насныхныг хамарсан, нийгмийн бүхий л давхаргын иргэдийн төлөөллөөс бүрдсэн бүтэцтэйгээр хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж байна.

Залуусын хөдөлмөр эрхлэлтэд онцгой хувь эзлэх бөгөөд үр чадвартай ирээдүйн ажиллах хүчийг бэлтгэхийн тулд сургалт, хөгжлийн бодлогоор хангадаг. Мөн ажлын анхны туршлагыг олгох чухал платформ болж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоо

Премиум Нэксус ХК нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажилд авах, ажиллуулах талаар нээлттэй бодлого, зохицуулалтыг хэрэгжүүлдэг. 2024 оны байдлаар нийт 129 хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллаж, тэдний ажлын гүйцэтгэл болон оролцоог дэмжих онцгой арга хэмжээнүүдийг авч байна. Тухайлбал, хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудад зориулан богиносгосон ажлын цагийн хуваарь санал болгож, үр чадвараа сайжруулах, карьер ахих боломжийг олгож, үнэ цэнтэй, урам зоригтой, өсөн дэвших боломжтой орчинд ажиллах нөхцөлийг хангахыг зорьдог.

Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийгмийн идэвх, өөртөө итгэх итгэлийг нэмэгдүүлж, бусад хамт олон, үйлчлүүлэгчдэд эергээр нөлөөлөхөд хувь нэмэр болж байна.

Олон талт тэгш байдал ба хүний нөөцийн үндсэн бодлогын тулгуур зарчмууд:

- Шударга, нээлттэй сонгон шалгаруулалт
- Тасралтгүй суралцаж, өсөж хөгжих нээлттэй байдал
- Олон талт тэгш байдал
- Сэтгэл ханамжтай ажилтан

Энэхүү бодлогын хүрээнд Премиум Нэксус ХК нь Хүртээмжтэй, Тэгш боломжийг хөдөлмөрийн зах зээлд бий болгохыг зорьж байна.

Ажиллах хүч /нас/	Ажилтны тоо	Эзлэх хувь
46-65 насны ажилтны тоо	146	3%
36-45 насны ажилтны тоо	444	9%
26-35 насны ажилтны тоо	1,010	20%
18-25 насны ажилтны тоо	3,483	68%
18 хүртэлх	62	1%

Хүйсийн бүтэц, жендерийн тэгш байдал

Үзүүлэлт	Эрэгтэй	Эмэгтэй
Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд (9)	77%	23%
Гүйцэтгэх болон дунд шатны удирдлага	46%	54%
Нийт ажилтан	28%	72%

Талент ба сургалт

Премиум Нэксус ХК нь байгууллагынхаа үнэт зүйлсийг өдөр тутмын үйл ажиллагаандаа шингээж, ажилтнуудын итгэл, урам зориг, өөртөө итгэх мэдрэмжийг бүрэн дэмжсэн ажлын орчныг бүрдүүлэхийг зорьдог. Ийм соёлтой орчин нь манай байгууллагын хамгийн үнэт капитал болох ажилтнуудын чадварыг бүрэн нээж, хөгжүүлэх суурь нөхцөлийг хангадаг.

Бид зах зээлээс шилдэг талентуудыг татахын зэрэгцээ дотоод ажиллах хүчээ сургаж хөгжүүлэхэд анхаарч, ажилтнуудаа үр чадвар, манлайллын чадавхтай, салбартаа үнэлэгдсэн үнэ цэн бүхий мэргэжилтнүүдийг бий болгох, төлөвшүүлэх зорилгоор сургалт, хөгжлийн бодлогыг хэрэгжүүлдэг.

Компанийн ажилтнууд үүрэгт ажлаа үр дүнтэй гүйцэтгэхийн зэрэгцээ өөрчлөгдөн буй бизнесийн орчны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ажлын байран дээрх сургалтын хөтөлбөрүүдэд хамрагддаг.

Ингэснээр ажилтнууд компанид зогсолтгүй өсөж, хөгжих боломжтой гэдэгт итгэж, байгууллагын амжилтад үрт хугацааны хувь нэмэр оруулах гал эрмэлзэлтэйгээр ажиллаж байна.

Ажилтан бүрийн үр чадвар, хэрэгцээ, шаардлагад нийцсэн сургалт, хөгжлийн системийг бүрдүүлж, түүнд тохирсон сургалт, хөгжлийн хөтөлбөрүүдийг санал болгодог. Ингэхдээ ажилтан бүрийн эзэмших шаардлагатай үр чадварыг үнэлж, үр чадварыг сайжруулах сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулан компанийн зүгээс дэмжиж ажилладаг.

Үзүүлэлт	Тоо хэмжээ
Сургалтын төрөл	16
Сургалтын нийт хүн цаг	49,317
Хамрагдсан ажилтын тоо (давхардсан)	17,988
1 ажилтанд ноогдох сургалтын цаг	2.7
Сургалтын зардал	555,844,661₮



Сургалт хөгжлийн бодлого

Сургалт хөгжлийн бодлого нь компанийн бизнес стратегитай уялдахаас гадна, ажилтан бүрийн карьерын зорилгодоо хүрэхэд нь дэмжлэг үзүүлэх хүн төвтэй зарчмыг баримталдаг. Премиум Нэксус ХК нь 2023 онд сургалтын цогц системээ шинэчилж, ажилтнуудын карьерын өсөлтөд бодитой нөлөө үзүүлэх хэд хэдэн хөтөлбөрийг хэрэгжүүлсэн.

Ажилтнуудын карьерын өсөлтийг дэмжих, суралцах үйл ажиллагааг дэмжих зорилгоор “Цалинтай сургалт” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд компанийн зохион байгуулж буй бүх сургалтад цалинтай хамрагдах боломжтой болсон. Мөн оффисын ажилтнуудын хувьд мэдлэгээ нэмэгдүүлэх, өөрийгөө хөгжүүлэх зорилгоор баасан гараг бүрийн 9-11 цагийг “Сургалт хөгжлийн цаг” болгон зарласан нь ажилтны өөрөө суралцах соёлыг төлөвшүүлэх чухал алхам болсон.

2025 оны байдлаар компани нь ажилтнуудыг ажлын байранд чиглүүлэх, дасан зохицуулах, мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх, мэдлэг олгох зорилгоор менежментийн нийт 16 төрлийн 49,317 хүн цагийн сургалтыг зохион байгуулсан бөгөөд давхардсан тоогоор нийт 17,988 ажилтныг хамруулсан. Энэ нь ажилтнуудын чадавхжуулах, мэргэшил дээшлүүлэхэд зохих дэмжлэг үзүүлж байна.

Түүнчлэн “Премиум Нэксус” ХК-ийн дэргэдэх сургалтын төв нь 2025 онд Хөдөлмөр, Нийгмийн Хамгааллын Сургалт, Үнэлгээ Судалгааны Институтийн баталгаажилтын дагуу “Худалдааны газрын үндсэн ажилтан” мэргэжилтэй ажилтан бэлтгэх тусгай зөвшөөрөл авсан. Энэ нь дэлгүүр дээр ажиллаж буй бүх ажилтнуудад мэргэжлийн үр чадвар эзэмших, ажлын орчинд таатай ажиллах нөхцөлийг бүрдүүлэх боломжийг олгож байна.

Ялангуяа сургалтын төвд суралцсанаар Монгол Улсын Боловсролын Яамнаас хүлээн зөвшөөрөгдсөн “Худалдааны газрын үндсэн ажилтан” мэргэжилтэй болж төгсөх боломжтой болсноор хөдөлмөр эрхлэх, тасралтгүй суралцах боломжийг бүрдүүлж байна.

Карьерыг дэмжих хөтөлбөрүүд

Премиум Нэксус ХК нь хүний нөөцийн тогтвортой өсөлт, хөгжлийг бий болгохын тулд шударга, ил тод үнэлгээний системээр дамжуулан ажилтнуудын карьер хөгжлийг дэмжин ажиллаж байна.

Карьер зэрэглэлийн үнэлгээ:

Ажилтнуудын ажлын үр дүн, мэргэжлийн үр чадварыг шударга, ил тод үнэлж, үнэлгээнд тэнцсэн ажилтнуудын карьерын шатлалыг ахиулдаг.

Тэгш боломж, олон талт байдлыг дэмжих:

Байгууллагын орчинд ялгаварлалгүй, эрх тэгш соёлыг төлөвшүүлэхийг зорьж, жендэрийн тэнцвэр, олон талт байдал, өөр өөр авьяас, чадварыг бүрэн дэмждэг. Ийнхүү, талант менежментийн бодлогоор дамжуулан байгууллага нь ажилтнуудынхаа үр чадварыг үнэлэх, карьерын өсөлтийн тэгш боломжийг хангах, тогтвортой орчныг бүрдүүлж, ажиллах хүчний үнэ цэнийг нэмэгдүүлж байна.




АЖИЛТНЫ СЭТГЭЛ ХАНАМЖ

Ажилтнуудынхаа сэтгэл ханамжийг олон улсын стандарт аргачлалаар тогтмол хэмжиж, үр дүнд нь үндэслэн урлаг, спорт, хувь хүний хөгжил, эрүүл мэндийг дэмжих олон талт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлснээр ажилтан бүрийг үнэ цэнтэй гэж мэдэрдэг, оролцоотой, эерэг соёлыг төлөвшүүлж чадсан байна. Үүний үр дүнд ажилтнуудын сүндсэн хэрэгцээ тогтвортой хангагдаж, багийн уур амьсгал хадгалагдан, гүйцэтгэлийг дэмжих суурь бүрдсэн нь байгууллагын тогтвортой өсөлтийн чухал үндэс болж байна.

2025 оны байдлаар Премиум Нэксус ХК нь ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгааг хагас жил тутам (2025.06 болон 2025.12) зохион байгуулж, ажлын орчин, удирдлага, хамтын ажиллагаа, хөгжлийн боломж зэрэг үндсэн үзүүлэлтүүдээр үнэлгээ хийсэн. Судалгааны нэгдсэн дүнгээр нийт сэтгэл ханамж 73% байгаа нь өмнөх хагас жилтэй харьцуулахад 1%-иар буурсан үзүүлэлттэй байна.

Ажилтнуудын үндсэн хэрэгцээний ханамж 84% байгаа нь харьцангуй өндөр түвшинд хадгалагдаж байна. Ажлын байрны шаардлага, ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай нөөц, хэрэгслээр хангагдсан байдал тогтвортой түвшинд байгаа нь эерэг үзүүлэлт юм. Хувь хүний хэрэгцээний ханамж 69% байгаа бөгөөд өмнөх үеийн түвшинг хадгалсан байна. Багийн харилцаа, хамтын ажиллагааны үзүүлэлт 73% байгаа боловч өмнөх хагас жилтэй харьцуулахад 1.5%-иар буурсан байна. Ялангуяа санал бодлыг хүлээн авах, байгууллагын зорилгын ойлголттой холбоотой үзүүлэлтүүд бага зэрэг буурсан хандлага ажиглагдаж байна. Ажилтнуудын өсөлт хөгжилтэй холбоотой үзүүлэлт 70% байгаа бөгөөд мөн 1.5%-иар буурсан байна. Сургалт, хөгжлийн боломж, удирдлагын зүгээс өгч буй дэмжлэгтэй холбоотой үнэлгээ харьцангуй сул байгаа нь анхаарал шаардсан чиглэл юм.

PREMIUM NEXUS LLC



Disengaged-2% өссөн

Highly Engaged-1% буурсан

Стратегийн зорилтууд

Үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх


CU аппликэйшны боломжууд

Үнэнч хэрэглэгчийн хөтөлбөр нь хэрэглэгчийг лоялти оноогоор шагнах, худалдан авалтын давтамжид суурилсан урамшуулал олгох, олон төрлийн дижитал үйлчилгээг санал болгох замаар урт хугацаанд хэрэглэгчдэд өгөх үнэ цэнийг нэмэгдүүлдэг. Тус хөтөлбөрийг CU аппликэйшнээр дамжуулан хэрэгжүүлж байна.

CU аппликэйшн бусад тоон мэдээллүүд:

2025 онд CU аппликэйшнийг хэрэглэгчдэд илүү хялбар, ойлгомжтой болгох шинэчлэл хийснээр нийт гүйлгээний 50 орчим хувь нь аппликэйшнээр хийгдсэн байна.

CU аппликэйшнд бүртгэлтэй хэрэглэгчдийн тоо 1.3 сая болж сард дунджаар 400 мянган хэрэглэгч тогтмол ашиглаж байна.



CU аппликэйшн хэрэглэгчдийн тоо			
	2024	2025	Өсөлт
CU аппликешн хэрэглэгч	1 сая	1.3 сая	31%
Идэвхтэй хэрэглэгч	269,723	400,517	48.5%



Стратегийн зорилтууд

Үнэнч хэрэглэгчдийг нэмэгдүүлэх



Финко Beep Virtual credit card

BEERXCU кредит карт 2025 оны 5-р сард амжилттай зах зээлд нэвтэрч, оны эцэст нийт 4000 орчим карт эзэмшигчтэй болоод байна

Голомт Virtual credit card

Голомтын кредит карт 2025 оны 12-р сарын байдлаар нийт 15 мянга орчим карт эзэмшигчтэй болоод байна.



Photoism

БНСУ-ын Seobuk Ltd-тай хамтран **Photoism** өөртөө үйлчлэх фото зургийн киоск төхөөрөмжийг франчайз эрхтэйгээр авч одоогийн байдлаар Hunnu 2222 хотхон, 64-р дэлгүүр, Сакура Тауэр салбаруудад суурилуулан ажиллаж байна.



Subscription

Бид CU апп-н үнэнч хэрэглэгчдэдээ урамшуулах зорилгоор **GET кофе**-ны бүх төрлийг илүү хямдаар урьдчилан авч уух боломжийг бүрдүүллээ.

Хүргэлт

Компанийн хүнс хүргэлтийн дижитал үйлчилгээ нь хэрэглэгчдэд илүү амар хялбар үйлчилгээ үзүүлэх, хэрэглэгчдийн дэлгүүрээр зочлох цаг зав, энергийг хэмнэх үнэ цэнийг санал болгох зорилгоор 2025 онд хүргэлтийн үйлчилгээг дахин нэвтрүүлэх ажлыг эхлүүлэн CU дэлгүүрийн 3-н салбарын 500 метрийн радиуст 30 минутын хүргэлтийн үйлчилгээг Minimum Viable Product түвшинд хэрэгжүүлж эхлэв.

Тасалбар борлуулалт

CU салбар дэлгүүрүүдээр дамжуулан үзвэр үйлчилгээ болон тоглолтын тасалбарыг худалдаалах боломжтой боллоо.

Стратегийн зорилтууд

Технологийн дэвшлийг нэвтрүүлэх

ISO/IEC 27001 Мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоо нэвтрүүлэлт

2025 онд **ISO/IEC 27001** Мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог нэвтрүүлж мэдээллийн аюулгүй байдлын бодлого, журам, хяналтын механизмуудыг тодорхойлон, тэдгээрийг өдөр тутмын үйл ажиллагаа болон технологийн шийдлүүдтэй уялдуулан системтэйгээр удирдах шинэ түвшинд шилжлээ.

Стандартын хүрээнд технологийн хамгаалалт, хяналтыг тогтмол сайжруулж, эрсдэлийг бууруулахын зэрэгцээ үйлчилгээний тасралтгүй ажиллагаа, бэлэн байдлыг хангах процессуудыг тасралтгүй хөгжүүлэн ажиллаж байна.

Үүний үр дүнд Компанийн мэдээллийн нүүцлал, бүрэн бүтэн байдал, хүртээмжийг хангах чадавх нэмэгдэж, үйлчилгээний найдвартай ажиллагаа болон хэрэглэгч, үйлчлүүлэгч, хамтран ажиллагч талуудын итгэлцлийг бэхжүүлэх суурь бүрдлээ.



EBarimt 3.0 системд хийгдсэн шинэчлэлүүд


2025 онд eBarimt систем тасалдалгүй, тогтвортой ажиллаж, хэрэглэгчдэд нийт **72 сая** орчим баримт олгосон байна.

Мөн 2025 оны 9-р сараас эхлэн банкны карт ашигласан худалдан авалтын eBarimt-ийг автоматаар бүртгэх шаардлагын дагуу хөгжүүлэлт хийж, амжилттай нэвтрүүлэв. Тус шийдэл нэвтэрснээс хойш банкны картаар хийгдсэн **1.5 сая** гаруй гүйлгээний eBarimt-ийг автоматаар бүртгэж, Монгол Улсын хууль тогтоомж болон төрийн захиргааны байгууллагуудаас ирүүлсэн шаардлагыг бүрэн ханган ажиллаж байна.




Үйл ажиллагааны гүйцэтгэл

Нийт сүлжээний борлуулалт (тэрбум төгрөгөөр)




Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




Ажилласан хүний тоо*

*Ажилласан хүний тоо буюу тухайн тайлант хугацаанд төлсөн нийгмийн даатгал төлөгчдийн тоо давхардаагүй дүнгээр.



Дэлгүүрийн тоо



Онцлох үйл явдлууд

2025 оны амжилт



Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгжийн 7-р байр

Премиум Нэксус ХК нь Монгол Улсын ТОП 100-д 5 дахь удаагаа шалгарч, дараах амжилтуудыг үзүүллээ:

- Борлуулалтын орлогоороо 25-р байр
- Төлсөн татварын дүнгээр 65-р байр
- Даатгуулагчийн тоогоор 2-р байр
- Ашгийн хэмжээгээр 42-р байр
- Хөрөнгийн эрэмбээр 51-р байр

Best for Youth – Залуучуудад ээлтэй шилдэг ажил олгогч

“Good Workplace Awards - 2025” нь 4 дэх жилдээ зохион байгуулагдаж байгаа ба хүндээ ээлтэй бодлого, ажилтны хөгжил, хүний нөөцийн салбарт Монголын тэргүүлэгч компаниудыг тодруулдаг цорын ганц үндэсний арга хэмжээнээс “Best for youth” залуучуудад ээлтэй шилдэг ажил олгогчоор шалгарлаа.

Премиум Нэксус ХК нь ажиллах хүчний бүтцийн хувьд 30 хүртэлх насны ажилчид нийт ажилтны 91.2%-ийг эзэлж, залуучууд энэ байгууллагын үндсэн хөдөлгөгч хүч болж байна.



Үндэсний чанарын чуулган-2025 Шилдэг үйлчилгээ

Чанар, инновац, байгууллагын өрсөлдөх чадварыг дэмжих зорилго бүхий Монгол Улсын Шадар сайдын ивээл дор зохион байгуулагддаг “Үндэсний чанарын чуулган” 10 дах жилдээ зохион байгуулагдсан бөгөөд 2025 онд Сэнтрал Фүүдс ХХК Шилдэг үйлчилгээ категорид шалгарлаа.

Онцлох үйл явдлууд

2025 оны амжилт

500 дахь салбараа амжилттай нээлээ

Монгол Улсын жижиглэнгийн худалдааны салбарт тэргүүлэгч Премиум Нэксус ХК нь “CU” брэндийг Монголд нэвтрүүлсний 7 жилийн ойгоо тохиолдуулан 500 дахь салбараа Төв аймгийн Цонжинболдогт нээлээ.

Энэхүү газар нь домогт өгүүлэгддэгээр 1177 онд Эзэн Чингис хаан дүү нарын хамт Хэрэйдийн Ван Тоорилд бараалхаад буцах замдаа ташуур олсон хэмээн бэлгэдэлтэй түүхтэй газар юм. Монгол ёсонд эр хүн ташуур олох нь сайн ерөөл, ирээдүйн их үйлийн бэлгэдэл хэмээн үздэг билээ.

Ийнхүү ивээлтэй, түүхэн дурсгалт газар 500 дахь салбараа нээсэн нь CU брэндийн тасралтгүй хөгжил, хамт олны түүштай хөдөлмөрийн бэлгэ тэмдэг төдийгүй үндэсний жижиглэнгийн салбарын шинэ шатны хөгжилд хүрсэн чухал үйл явдал боллоо.



Retail Asia Awards-аас “Convenience Store of the Year - Mongolia” шагнал хүртсэн

- > Премиум Нэксус компани 2018 онд CU брэндийг Монголд амжилттай нэвтрүүлж, 480+ салбар, 3,500+ ажилтантай үндэсний хамгийн том жижиглэнгийн сүлжээг бий болгожээ.
- > CU нь өдөр бүр 220 гаруй мянган хэрэглэгчийг хүлээн авч, 400+ нийтийн ариун цэврийн өрөө, оюутнуудад зориулсан уян хатан ажлын байр зэргээр хэрэглэгчдэд ээлтэй орчныг бүрдүүлсээр байна.
- > CU апп, CU Pay зэрэг технологид суурилсан үйлчилгээг нэвтрүүлж, жижиглэн худалдааны шинэ дижитал үеийг Монголд авч ирсэн нь онцлох жишээ юм.

Тус нэр хүндтэй шагнал нь Ази-Номхон далайн бүсийн жижиглэн худалдааны салбар дахь шилдэг туршлага, инновацыг үнэлдэг бөгөөд Монголын зах зээлд конвениенс дэлгүүрийн соёлыг амжилттай нэвтрүүлсэн Премиум Нэксус компанийн үйл ажиллагаа, өсөлт, нийгмийн хариуцлагатай бодлогын үр дүн юм.

Премиум Нэксус ХК-ийн бүртгэл II ангилалаас I ангилалруу шилжлээ

2025 оны 9-р сарын 5-ны өдөр Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн Гүйцэтгэх захирлын А/358 тоот тушаалаар Премиум Нэксус ХК-ийн бүртгэл II ангиллаас I ангилалд албан ёсоор шилжсэн.

Энэхүү шилжилт нь Компанийн сайжирсан санхүүгийн үзүүлэлт, ил тод байдал, хамгийн өндөр түвшний засаглалын стандартын дагуу үйл ажиллагаа явуулж буй байдлыг тусгасан үр дүн юм.



Онцлох үйл явдлууд

Delivery үйлчилгээг нэвтрүүлээ

Орчин үед хүргэлтийн үйлчилгээ хэрэглэгчдийн өдөр тутмын амьдралын салшгүй нэг хэсэг болж байна. Энэ чиг хандлагад нийцүүлэн CU конвениенс дэлгүүр 2025 оны 9-р сараас эхлэн хүргэлтийн үйлчилгээгээ дахин сэргээн нэвтрүүллээ.

Тус үйлчилгээ нь анх COVID-19 цар тахлын үеэр хэрэгжиж байсан бөгөөд тодорхой хугацаанд завсарласны дараа одоо сонгогдсон бүсүүдийг хамруулан дахин үйл ажиллагаагаа эхлүүлээд байна.

Хэрэглэгчид CU аппликэйшнээр дамжуулан бүтээгдэхүүнээ хүргэлтээр захиалах, хүргэлтийн явцыг реал тайм статусаар хянах боломжтой болсон нь хэрэглээний тав тухыг улам нэмэгдүүлж байна.

Мөн цаашид хүргэлтийн хамрах хүрээг шат дараатайгаар өргөжүүлэх, системтэй цэгүүдийг нэмэгдүүлэх төлөвлөгөөтэй байгаа нь Компанийн дижитал үйлчилгээний хөгжлийн стратегийн чухал алхам юм.

Хүйтний улирал эхэлж буй энэ үед гэртээ байгаа ээжүүд болон завгүй хэрэглэгчдэд зориулсан энэхүү шийдэл нь хэрэглэгчийн хэрэгцээнд нийцсэн, нүдээ олсон үйлчилгээ болж байна.



Онцлох үйл явдлууд

Нийгэм олон нийт рүү чиглэсэн ажлууд

Эрүүл мэндийн салбарт 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ

Премиум Нэксус ХК-ийн CU брэнд нь 2025 онд нийтийн эрүүл мэндийн хүртээмж, орчны стандартыг дээшлүүлэх зорилгоор нийт арван эмнэлгийн ариун цэврийн өрөө болон орчныг сайжруулах, шинэчлэх ажилд 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, тохижилтын ажлуудаа албан ёсоор хүлээлгэн өглөө.

CU конвينيенс дэлгүүр 500 гаруй салбар дэлгүүрүүдээрээ дамжуулан олон нийтийн хүртээмжтэй, цэвэр, тохилог ариун цэврийн өрөөг үнэ төлбөргүй ашиглуулах бодлогыг тогтвортой хэрэгжүүлж ирсэн. Эрүүл мэндийн салбарыг дэмжих энэхүү төсөл нь тус Компанийн нийгэмд өгч буй бодит эерэг нөлөөллийн үргэлжлэл юм.



Монголын Волейболын Холбооны тэргүүн түнш байгууллагаар Премиум Нэксус ХК болон CU брэнд болов

Премиум Корпорэйшн болон Монголын Волейболын Холбоо нь хамтын ажиллагааны 4 жилийн гэрээг байгуулж, тус холбооны Тэргүүн түнш байгууллагаар Премиум Нэксус ХК болон CU брэнд тодорлоо.

Премиум Корпорэйшн, CU брэнд энэхүү хамтын ажиллагаагаар дамжуулан ирээдүй хойч үе болсон залуус, өсвөр үеийнхний чөлөөт цагийг зөвөөр өнгөрүүлэх, биеийн болон сэтгэлийн эрүүл мэндийг дэмжих, спортыг амьдралын нэг хэсэг болгох соёлыг түгээхэд тууштай ажиллах болно.



Хамтын ажиллагааны хүрээнд дөрвөн жилийн хугацаанд нийт 7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон бөгөөд уг хөрөнгө оруулалтаар дараах гол зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Энэхүү санаачилга нь Монголын спортын хөгжлийн түүхэнд анхны удаа хувийн хэвшлийн байгууллага үндэсний спортын холбоотой урт хугацааны, бодит хэмжээний санхүүгийн түншлэл байгуулж байгаа гэдгээрээ онцлог бөгөөд волейболын спортыг шинэ түвшинд гаргах, тогтвортой хөгжүүлэхэд чухал түлхэц болох юм.

Онцлох үйл явдлууд

Хүүхэд хамгаалал, хүүхдийн төлөөх ажлууд

“365 Анхаарч Хайрлая” аян

ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх хэлтэс **CU & GS25** брэндүүд хамтран “Өдөр бүр анхаарч хайрлая” буюу 365 аяныг эхлүүлсэн юм. Энэхүү аян нь 2026 онд мөн бүтэн жилийн турш үргэлжлэх бөгөөд аяны хүрээнд CU брэнд өсвөр үеийнхнийг хорт зуршлаас урьдчилан сэргийлэх, түүний сөрөг нөлөөг таниулан сурталчлах ажилд идэвхтэй оролцоно.

Өсвөр үеийн хорт зуршлын хэрэглээг бууруулах зорилгын хүрээнд CU конвينيенс дэлгүүр насны хязгаарлалттай бүтээгдэхүүн борлуулах үедээ чанга яригчаар автомат сануулга өгөх шийдлийг бүх салбарт нэвтрүүлсэн.



ICU төсөл ЦЕГ 102 аппликэйшнтэй хамтран үйл ажиллагаагаа өргөжүүлээ

CU брэнд 2021 оноос эхлэн “**СУ ЧАМД ТУСАЛБЯ**” уриатай **ICU** хүүхэд хамгааллын төслийг амжилттай хэрэгжүүлж эцэг эхээсээ төөрсөн 14 хүүхдийг дэлгүүрт аюулгүй байлгаж, эцэг эхэд нь хүлээлгэн өгсөн бөгөөд энэхүү ажиллагаанд цагдаагийн газартай хамтран ажилласаар байна.

2025 оны 5-р эхлэн хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн ЦЕГ-ийн 102 аппликэйшнтэй холболт хийж, төөрсөн, сураггүй алга болсон хүүхдийн мэдээллийг CU конвينيенс дэлгүүрийн бүх салбарын POS дэлгэцүүдээр олон нийтэд шуурхай хүргэх ажлуудыг зохион байгуулж байна.

CU брэндийн санхүүжилтээр “Magic Box” номын сан шинээр нээгдлээ

CU брэнд 2020 оноос эхлэн хүүхэд хамгааллын төсөл, хөтөлбөрүүдийг тасралтгүй хэрэгжүүлсээр ирсэн. Энэ удаад бид хүүхдүүдэд зориулсан шинэ, дулаан, хэрэгцээтэй орон зайг бүтээхээр 200 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Чингэлтэй дүүргийн хоёр байршилд “**Magic Box**” номын санг байгуулж, бүрэн тохижуулан албан ёсоор хүлээлгэж өглөө.



Хүнсний аюулгүй байдал

Премииум Нэксус ХК нь хэрэглэгчийн аюулгүй байдал, бүтээгдэхүүний чанарыг үйл ажиллагааныхаа тэргүүлэх чиглэл болгон 2025 онд тогтвортой гүйцэтгэл үзүүлэн ажиллалаа. Тайлант хугацаанд бүтээгдэхүүний ноцтой гомдлын түвшинг бууруулах зорилтыг амжилттай хэрэгжүүлж, 1 сая бүтээгдэхүүнд ногдох ноцтой гомдлын үзүүлэлтийг 7.54 түвшинд барьж, тогтоосон зорилтот түвшинд хүрсэн байна.

Нийт гомдлын бүтэц, шалтгаанд тогтмол дүн шинжилгээ хийж, чанарын хяналтын арга хэмжээг сайжруулсны үр дүнд энгийн гомдлын түвшин өмнөх оноос мэдэгдэхүйц буурсан нь хэрэглэгчийн сэтгэл ханамжид эерэг нөлөө үзүүлсэн үзүүлэлт боллоо.

Компанийн нийлүүлэлтийн сүлжээнд чанар, хүнсний аюулгүй байдлын шаардлагыг хангах зорилгоор бэлтгэн нийлүүлэгчдийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, стандартын хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. 2025 онд нийлүүлэгчдийн хүнсний аюулгүй байдлын нийцлийн түвшин 90 хувьд хүрсэн бөгөөд цаашид энэхүү үзүүлэлтийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Мөн чанарын хяналтын үнэлгээний системийг тасралтгүй сайжруулж, QSC болон QA үнэлгээний дундаж үзүүлэлтүүдийг тогтвортой өсгөж, үйл ажиллагааны стандарт мөрдөлтийг бэхжүүлж байна.

Премииум Нэксус ХК нь ажилтнуудын мэдлэг, үр чадварыг нэмэгдүүлэхэд онцгойлон анхаарч, 2025 онд чанарын чиглэлийн сургалт, заавар зөвлөмжийг өргөн хүрээнд зохион байгууллаа. Тайлант хугацаанд нийлүүлэлтийн болон дэлгүүрийн нийт 400 гаруй ажилтныг хамруулсан сургалт зохион байгуулж, ажлын байрны өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай мэдлэгийг бэхжүүлсэн.

Мөн богино хэмжээний сургалтын контент ашиглан ариун цэвэр, бүтээгдэхүүний хадгалалт, хугацааны хяналт зэрэг чухал үйл явцыг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар түгээж, чанарын соёлыг байгууллагын хэмжээнд төлөвшүүлэхэд анхаарч ажилласан.

Компанийн үйл ажиллагаанд холбогдох хууль, стандартын шаардлагыг хангах хүрээнд ариутгал, халдваргүйжүүлэлт, усны шинжилгээ болон бүтээгдэхүүний хяналтын шинжилгээг тогтмол зохион байгуулж байна. 2025 онд нийт мянга гаруй удаагийн ариутгал, усны шинжилгээ, бүтээгдэхүүний хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлж, эрүүл ахуйн шаардлагыг ханган ажиллалаа.

Мөн шинжилгээ, хяналтын давтамж, хамрах хүрээг үе шаттайгаар сайжруулж, бүх салбар нэгжүүдийг бүрэн хамруулахад анхаарч байна.

Компанийн үйл ажиллагаанд тасралтгүй сайжруулалтын зарчмыг хэрэгжүүлж, ариун цэвэр, ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх шинэ шийдлүүдийг туршин нэвтрүүлж байна. Үүнд цэвэрлэгээ, ариутгалын үйл ажиллагааг хялбаршуулах, стандартчилах, шинэ технологи, хэрэгслийг ашиглах боломжийг судлан хэрэгжүүлж байна.

2025 онд Премииум Нэксус ХК нь бүтээгдэхүүний чанар, хэрэглэгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлд гомдлын удирдлагын тогтолцоог тогтмол сайжруулан ажилласан байна. Тайлант хугацаанд FF болон ISF бүтээгдэхүүнтэй холбоотой нийт 421 ноцтой гомдол бүртгэгдсэн бөгөөд үүний 76.2 хувийг FF бүтээгдэхүүн, 23.7 хувийг бусад төрлийн бүтээгдэхүүнтэй холбоотой гомдол эзэлж байна. Ноцтой гомдлын үзүүлэлтийг борлуулалтын хэмжээнд харьцуулсан дүнгээр тооцоход 1 сая бүтээгдэхүүнд ногдох гомдлын түвшин 7.54 болж, 7.6 гэсэн зорилтот түвшинд хүрч, төлөвлөсөн гүйцэтгэлийг ханган ажилласан байна.

Ноцтой гомдлын сарын динамикийг өмнөх онуудтай харьцуулахад 2025 онд хэлбэлзэл харьцангуй тогтворжсон, зарим оргил үеүүд буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь чанарын хяналт, дотоод үйл ажиллагааны сайжруулалтын арга хэмжээнүүд бодит үр дүнгээ өгч эхэлснийг илтгэж байна.

Мөн 2025 онд FF бүтээгдэхүүнтэй холбоотой нийт 606 энгийн гомдол бүртгэгдсэн байна. Энгийн гомдлын үзүүлэлтийг 1 сая бүтээгдэхүүнд ногдох байдлаар өмнөх онтой харьцуулахад 2025 онд 2024 оноос 28.75 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа нь хэрэглэгчийн сэтгэл ханамж, бүтээгдэхүүний тогтвортой чанар сайжирч байгааг харуулж байна.

Энгийн гомдлын сарын өөрчлөлтийг харахад 2025 онд өмнөх онуудтай харьцуулахад өндөр хэлбэлзэл багасч, илүү тогтвортой түвшинд хадгалагдсан нь гомдлын удирдлагын систем болон урьдчилан сэргийлэх арга хэмжээнүүдийн үр нөлөө нэмэгдсэнийг илтгэнэ.

Хэрэглэгчийн гомдлын менежмент ба хүнсний аюулгүй байдал

2025 онд зөвхөн Call Center (+976) 77330101 шугамаар 29529 хэрэглэгчийн санал гомдлыг хүлээн авч, бүрэн шийдвэрлэсэн нь гомдлын менежментийн тогтолцоо тогтвортой сайжирч, ханган нийлүүлэгчдийн чанарын хяналт, хариуцлагын механизм улам нарийсч байгааг илтгэж байна. Компани нь гомдлыг үнэлэх, ангилах, хянах, дахин давтагдахаас сэргийлэх механизмыг олон улсын менежментийн стандартуудтай уялдуулан хэрэгжүүлж байна.

CU app-н талаар мэдээлэл авсан	5021
IPO хувьцааны талаар	26
Ажилтны дугаар авсан	700
Ажилчидтай холбоотой	149
Ажлын байрны талаар	1111
Бараа бүтээгдэхүүний мэдээлэл	3203
Бусад	3934
Бусад дуудлагатай холбоотой	855
Бүтээгдэхүүн нийлүүлэх хүсэлт	67
Бэлгийн карт болохгүй	41
Бэлгийн картын талаар	18
Гомдол	1894
Гомдол - Бүтээгдэхүүтэй холбоотой	161
Гомдол - Дэлгүүртэй холбоотой	109
Гомдол - Үйлчилгээтэй холбоотой	273
И-Баримттай холбоотой	94
Кредит карттай холбоотой	184
Сайшаал магтаал өгсөн	16
Санал хүсэлт өгсөн	1346
Төлбөрийн буцаалт, илүү таталттай холбоотой	5107
Франчайз хөтөлбөрийн талаар	881
Харилцагчтай холбоотой асуудал	1011
Хаяг байршил, цагийн хуваарь асуусан	1343
Хүргэлттэй холбоотой	253
Шинэ дэлгүүртэй холбоотой	753
Эд зүйлээ үлдээсэн	979

Хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгч нарын хөгжил дэвшил

2022 оноос CU сүлжээ дэлгүүр нь бэлтгэсэн хоол нийлүүлэгч нарын чадавхыг сайжруулах чиглэлээр хөтөлбөрийг санаачлан эхлүүлсэн. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор хамтран ажилладаг хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгч нартаа ажлын байрны угтвар нөхцөлийг сайжруулах, эрүүл ахуйн дадал хэвшлийг байнга мөрдөж хэвшүүлэх зорилгоор НАССР (НАССР) стандартыг хэрэгжүүлэх “Хамтдаа хөгжье” хөтөлбөрийг 4 үе шаттайгаар хэрэгжүүлээ. 2023 онд нийт 6 нийлүүлэгч НАССР стандартыг хэрэгжүүлсэн бөгөөд 2024 оны байдлаар нийт 11 үндэсний үйлдвэрүүд НАССР стандартын баталгаажилтад хамрагдаж сертификатаа авсан. Эдгээр аж ахуйн нэгжүүд НАССР-ийн стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр түүхий эд бэлтгэн нийлүүлэлтээс эхлэн үйлдвэрлэх, түгээх, хадгалах, хэрэглэгчид хүргэх бүхий л үе шатанд бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг ханган нарийн хяналт шалгалтын дор эрүүл, баталгаатай хоол хүнс үйлдвэрлэх, хэрэглэгчдэд найдвартай аюулгүй бүтээгдэхүүнээр үйлчлэх боломжтой болж байна. 2025 ондоо CU сүлжээ дэлгүүр нь дахин 5 нийлүүлэгчийг НАССР стандарт хэрэгжүүлэн баталгаажуулалтад хамруулах зорилготой бэлтгэл ажилдаа орж, амжилтад хүрэхэд тогтвортой хүч үзэхээр төлөвлөж байна.

НАССР стандарт хэрэгжүүлсэн 16 үндэсний үйлдвэрлэгч нартай CU сүлжээ дэлгүүр хамтран ажиллаж байна.

Хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах арга хэмжээ

2025 онд CU сүлжээ дэлгүүр нь хүнсний аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах зорилгоор бэлтгэсэн хоолны бүтээгдэхүүн нийлүүлэгчид, түгээлтийн машин, салбар дэлгүүрүүд зэрэг гол дамжин өнгөрдөг цэгүүд дээр хяналтаа сайжруулан ажиллаж байна. Энэхүү арга хэмжээний үр дүнд 2024 онтой харьцуулахад гомдлыг 15%-иар бууруулсан үзүүлэлттэй байна. Энэ нь CU сүлжээ дэлгүүрийн хүний аюулгүй байдлын менежментийн тогтолцооны үр ашиг болон хүнсний бүтээгдэхүүний чанарт анхаарал хандуулж, эрсдэлийг зохих хэмжээгээр бууруулахад томоохон хувь нэмэр оруулж буйг илтгэж байна.



Хот суурин газрыг сайжруулах үйл ажиллагаа

CU дэлгүүрээр үйлчлүүлж буй сая сая хүн дараах үйлчилгээг ямар нэг худалдан авалт хийх нөхцөлгүйгээр санал болгож, нийслэл болон салбар дэлгүүр байршиж буй орон нутгийн хоол үйлчилгээний соёл, стандартыг өөр түвшинд авчраад 5 жил болжээ.




Ариун цэврийн газар:

Нийслэл болон орон нутагт олон нийтийн ариун цэврийн байгууламжийг дангаар шийдэж өгсөн нь нийслэлийн иргэдийг ая тохитой амьдрах, олон жилийн турш гаргалгаа олдоогүй асуудлын шийдлийг бий болгосон хэрэг юм.



Гадна талбайн цэвэрлэгээ:

CU дэлгүүрүүд гадаад орчны 50м талбайгаа тохижуулсан гэрэлтүүлэгтэй, халтиргаа гулгаанаас хамгаалж цэвэрлэсэн байх шаардлага тавьдаг.



24 цагийн камержуулалт:

1 сарын хугацаатай хадгалагддаг камерын бичлэг хийгддэг бөгөөд хүмүүс юмаа мартаж орхих, хулгай, гэмт хэрэгт өртөх гэх мэт тохиолдлуудад холбогдох байгууллагын зөвшөөрлөөр бичлэг шүүж нотолгоо болсон тохиолдлууд бий.



Үнэгүй Wi-Fi цэг:

Хотын төв гэлтгүй захын бүсүүдэд кофе шоптой адил үйлчилгээ үзүүлэх ач холбогдолтой юм.



Шуудангийн үйлчилгээ:

Stora хүргэлтийн цэгүүд тодорхой цэгүүдэд байрласан. Мөн төрийн үйлчилгээний киоск цэгүүдийг байрлуулахаар төрийн холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Тогтвортой өртгийн сүлжээний менежмент

6.1: Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?
6.2: Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь
6.3: Тогтвортой, ногоон худалдан авалт	Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь

Нийт худалдан авалтын зардлын бүтцийг харахад дотоодын нийлүүлэлт давамгайлж байна. Тодруулбал, нийт 572.3 тэрбум төгрөгийн худалдан авалтын зардлын 95.95 хувь буюу 549.1 тэрбум төгрөгийг дотоодын нийлүүлэгчдээс бүрдүүлж байгаа бол 4.05 хувь буюу 23.2 тэрбум төгрөгийг олон улсын эх үүсвэрээс хангаж байна.

Энэ нь компанийн үйл ажиллагаанд дотоодын нийлүүлэлтийн сүлжээг дэмжих, үндэсний үйлдвэрлэл болон бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлд өндөр хувь нэмэр оруулж байгааг илтгэж байна. Мөн нийлүүлэлтийн эрсдэлийг бууруулах, логистикийн зардлыг хянах, орон нутгийн эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх давуу талтай.

Үзүүлэлт	Тоо хэмжээ	Хувиар
Гадаад худалдан авалт	23,189,221,608	4.05 %
Дотоод худалдан авалт	549,121,515,751	95.95 %
Нийт	572,310,737,359	100 %

2025 онд CU-д 6408 нэр төрлийн бүтээгдэхүүнийг 563 нийлүүлэгч нийлүүлснээс 85,3% буюу 285 нь үндэсний үйлдвэрлэгч байна.

Нийт ханган нийлүүлэгчдийн 0,029% нь байгаль орчинд ээлтэй бүтээгдэхүүн нийлүүлдэг бол 0,014% нь байгаль орчинд сөрөг нөлөөтэй бүтээгдэхүүн нийлүүлдэг.

Аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа

Компани ажилтан болон хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахыг үйл ажиллагааныхаа тогтвортой байдлын үндэс гэж үзэн, ХАБЭА-н менежментийн тогтолцоог гүйцэтгэх удирдлагын шууд хяналт дор PDCA (Төлөвлөх-Хэрэгжүүлэх-Хянах-Сайжруулах) зарчмаар тасралтгүй сайжруулан ажиллаж байна. Мөн аюултай нөхцөлд ажлыг зогсоох эрхийг ажилтан бүрт олгож, зөрчлийг нээлттэй мэдээлэх орчныг бүрдүүлснээр байгууллагын хэмжээнд “үл буруутгах” соёлыг төлөвшүүлэн ажиллаж байна. Түүнчлэн ачааллаас үүдэлтэй ядрал, анхаарал сулрах эрсдэлийг бууруулахад чиглэсэн ядаргааны менежментийн арга хэмжээг авч, эрүүл мэндийн тогтмол хяналтыг хэрэгжүүлж байна.

Осол, зөрчлийн шалтгааныг системтэйгээр судалж, дахин давтагдахаас урьдчилан сэргийлэхийн зэрэгцээ дижитал шийдлийг нэвтрүүлснээр аюулын бүртгэл, хяналтын гүйцэтгэл илүү шуурхай, ил тод болсон. Бид гэрээт болон туслан гүйцэтгэгчдэд ХАБЭА-н ижил түвшний шаардлага тавьж ажилладаг бөгөөд үүний зэрэгцээ ажилтнууд болон холбогдох талуудыг төрөл бүрийн даатгалд хамруулах замаар болзошгүй эрсдэлийн нөлөөллийг бууруулах менежментийн арга хэмжээг хэрэгжүүлж байна. Ингэснээр аюулгүй ажиллагааны нэгдсэн тогтолцоо болон соёлыг байгууллагын хэмжээнд төдийгүй хамтран ажиллагч талуудад төлөвшүүлж, тогтвортой хөгжлийн зорилтыг дэмжин ажиллаж байна.

Эрсдэлийн үнэлгээнээс бодит өөрчлөлт рүү

Бид эрсдэлийн үнэлгээний үр дүнд тулгуурлан ажлын байрны нөхцөлийг сайжруулах бодит арга хэмжээнүүдийг тогтмол хэрэгжүүлж байна. Тухайлбал, 2025 оны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээний дүнг үндэслэн салбар дэлгүүрүүдийн агааржуулалтын системийг шинэчлэх, гэрэлтүүлэг болон дуу чимээний түвшнийг стандартад нийцүүлэх зэрэг ажилтны ажиллах орчныг эрүүлжүүлэх хөрөнгө оруулалтуудыг хийж гүйцэтгэлээ. Ингэснээр эрсдэлийн үнэлгээ нь зөвхөн оношилгооны хэрэгсэл бус, ажлын байрны чанарыг дээшлүүлэх, эрсдэлийг бууруулах шийдвэр гаргалтын үндсэн баримт бичиг болж байна.

Ажилтны оролцоо: Аюул илрүүлэлтийн шинэ түвшин

Аюулгүй ажиллагааг хангахад ажилтны идэвх оролцоог чухалчлан, аюул болон зөрчлийг нээлттэй мэдээлэх соёлыг төлөвшүүлэхэд бид онцгойлон анхаарч байна. 2025 оны 4 дүгээр сараас эхлэн ХАБЭА-н “Бөхбат” аппликейшнийг үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр аюул илрүүлэх, мэдээлэх үйл явцыг бүрэн дижитал хэлбэрт шилжүүлсэн билээ. Энэхүү тогтолцооны суурь тавигдаж байсан 2024 онд ажилтнууд нийт 66 аюулыг мэдээлж байв. Харин 2025 онд тус аппликейшнийг бүрэн ашиглаж эхэлснээр аюул илрүүлэлтийн идэвх нэмэгдэж, нийт 2,178 аюулыг бүртгэсэн нь ажилтнуудын эрсдэлийг олж харах чадвар болон мэдээлэх хандлага эрс сайжирсныг илтгэж байна. Бид илрүүлсэн аюулыг зөвхөн бүртгээд зогсохгүй, тэдгээрийг шуурхай арилгахад төвлөрч ажилласнаар нийт аюултай нөхцөлийн 98.5 хувь буюу 2,145 зөрчлийг богино хугацаанд засаж сайжрууллаа. Энэхүү үр дүн нь манай компанийн эрсдэлийг урьдчилан удирдах тогтолцоо бодитой, үр дүнтэй хэрэгжиж буйн баталгаа юм.

ХАБЭА сургалт

Ажилтнуудыг болзошгүй эрсдэлээс өөрийгөө болон бусдыг хамгаалах мэдлэгтэй болгох, аюулгүй ажиллагааны соёлыг төлөвшүүлэх үйл явцыг сургалтын нэгдсэн тогтолцоогоор дамжуулан хэрэгжүүлж байна. Мэдлэгийг тасралтгүй шинэчлэх, үр чадварыг бататгах зорилгоор танхимын болон цахим сургалтын хосолсон хэлбэрийг үйл ажиллагаандаа ашигладаг.

Энэхүү стратегийн хүрээнд 2025 онд ХАБЭА-н үндсэн чиглэлүүдийг хамарсан 9 төрлийн модуль сургалтыг танхимаар зохион байгуулж, нийт 876 ажилтныг хамрууллаа. Сургалтын агуулга нь ажлын байрны онцлогт тохирсон бодит тохиолдол дээр суурилсан бөгөөд ажилтнуудын аюулгүй ажиллагааны үр чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн болно.

Шинэ ажилтнуудыг ажлын байранд эхний өдрөөс аюулгүй ажиллагааны шаардлагыг ойлгож мөрдөх нөхцөлөөр хангах зорилгоор анхан шатны зааварчилгааг цахим хэлбэрээр олгож хэвшсэн. 2025 онд шинэ ажилтнуудыг уг сургалтад бүрэн хамруулснаар байгууллагын аюулгүй байдлын соёл, стандартыг нэгдсэн нэг ойлголттойгоор эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүллээ.

Д/д	Сургалтын төрөл	Сургалт зохион Байгуулсан хэлбэр
1	Сэрээт ачигчын оператор	Мэргэжлийн байгууллага
2	Ачаат өргүүрийн оператор	Мэргэжлийн байгууллага
3	Нийт ажилтны ХАБЭА-н сургалт /Кроссдок/	Мэргэжлийн байгууллага
4	Галын аюулгүй байдлын сургалт	Дотоод
5	“Харшилтай тэмцэх” дэлхийн өдөр	Мэргэжлийн байгууллага
6	ХАБЭА-н чиглэл олгох сургалт	Дотоод
7	Тамхины хор хөнөөл, тамхи татахыг хориглох тухай давтан заавар	Дотоод
8	Журам танилцуулах сургалт	Дотоод
9	Химийн бодис, асгаралтын иж бүрдэл ашиглах сургалт	Дотоод
10	Гамшигаас хамгаалах төлөвлөгөө танилцуулах сургалт	Дотоод
11	Аюулгүй ажиллагааны төлөвшлийн загварчлал	Мэргэжлийн байгууллага
12	HSE UPDATE FORUM 2024	Мэргэжлийн байгууллага
13	Анхны тусламж үзүүлэгч	Мэргэжлийн байгууллага
14	Гал түймрийн тархалтын сургалт дадлага	Мэргэжлийн байгууллага
15	Ногоон бизнесийг хөгжүүлэх хурдасгуур хөтөлбөрийн сургалт	Мэргэжлийн байгууллага

Ажилтны аюулгүй байдал

Ажилтнуудын эрүүл, аюулгүй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх нь компанийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл бөгөөд үүнийг техникийн болон зохион байгуулалтын иж бүрэн арга хэмжээгээр ханган ажиллаж байна. Энэ хүрээнд ажлын байрны эрсдэлийг бууруулах зорилгоор физик хамгаалалт, дижитал хяналт болон шуурхай хариу арга хэмжээний нэгдсэн тогтолцоог нэвтрүүлсэн.


Салбар нэгжүүдийг 24 цагийн камерын хяналтын системд холбож, болзошгүй аюул, эрсдэл үүссэн нөхцөлд шуурхай хариу үзүүлэх боломжийг бүрдүүлж байна. Мөн аюултай нөхцөл байдлын үед хамгаалалтын багийг богино хугацаанд дуудах дохиоллын шийдлийг хэрэгжүүлснээр ажилтнуудын аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдсэн.

Даатгал

Байгууллага нь ажилтнууд, үйл ажиллагааны тасралтгүй байдал болон харилцагч талуудад үүсэж болзошгүй эрсдэлийг бууруулах зорилгоор даатгалын нэгдсэн тогтолцоог хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэ хүрээнд ажилтнуудыг гэнэтийн ослын даатгалд хамруулж, үйлчлүүлэгчдийн өмнө хүлээх хариуцлагыг “Ерөнхий хариуцлагын даатгал”-аар баталгаажуулсан. Мөн салбар нэгж болон бараа материалын аюулгүй байдлыг “Эд хөрөнгийн даатгал”-аар хамгаалснаар болзошгүй эрсдэлээс үүдэн гарч болох санхүүгийн нөлөөллийг бууруулах найдвартай нөхцөлийг бүрдүүлээд байна.

Даатгалын төрөл	Даатгалд хамрагдагсад
Гэнэтийн ослын даатгал	Байнгын гадуур ажилладаг оффисын ажилчид, түгээлтийн төв, үйлдвэрийн ажилчид
Олон улсын эрүүл мэндийн даатгал	Томилолтоор ажиллах удирдлагын түвшний ажилтан
Томилолтын гэнэтийн ослын даатгал	Томилолтоор ажиллах ажилчид
Байгууллагын ерөнхий хариуцлагын даатгал	Бүх үйл ажиллагаа
Эд хөрөнгийн даатгал	Дэлгүүр, хуурай түгээлтийн төв, хүйтэн хэлхээт түгээлтийн төв, бүтээгдэхүүн хөгжүүлэлтийн гал тогоо
Бараа материалын үлдэгдлийн даатгал	Дэлгүүр, хуурай түгээлтийн төв
Тээврийн хэрэгслийн даатгал	Барилга ашиглалтын албаны машин

ЗАСАГЛАЛ



Компанийн засаглалын кодекс

Санхүүгийн зохицуулах хорооноос гаргасан 2025 оны I хагас жилийн Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээний тайланд Премиум Нэксус ХК 98.6 хувийн үнэлгээ авч, нээлттэй хувьцаат компаниудын дундаас **тэргүүлэгчдийн** эгнээнд эрэмбэлэгдлээ.

2025 оны энэхүү үнэлгээ нь компанийн хувьд **түүхэн дээд амжилт болж**, Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн оноо өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 оноогоор өсөж, боломжит 72 онооноос 71 оноо авсан нь засаглалын тогтолцоо, ил тод байдал, хариуцлагын стандартууд тогтвортой сайжирч буйг илтгэж байна. Энэхүү амжилт нь компанийн засаглалын соёлыг бэхжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлд түүштай ажилласны бодит үр дүн юм.

Агуулга	Авбал зохих нийт оноо	Авсан оноо 2023	Үнэлгээний хувь 2023	Авсан оноо 2024	Үнэлгээний хувь 2024	Авсан оноо 2025	Үнэлгээний хувь 2025
ТҮЗ-ийн бүтэц, зохион байгуулалт	12	12	100%	8	67%	10	83.3%
ТҮЗ-ийн дэргэдэх хороод, тэдгээрийн чиг үүрэг	10	9	90%	9	90%	7	70%
Тайлагнал, мэдээллийн ил тод байдал	6	6	100%	5	83%	5	83.3%
Аудит, хяналтын тогтолцоо	6	5	83%	6	100%	6	100%
Эрсдэлийн удирдлага	8	8	100%	8	100%	8	100%
Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшуулал	6	6	100%	6	100%	6	100%
Оролцогч талуудын эрх ашиг	8	8	100%	8	100%	8	100%
Компанийн соёл	6	6	100%	6	100%	6	100%
Хувьцаа эзэмшигчдийн эрх	10	9	90%	10	100%	10	100%
Нэгдсэн дүн	72	69	95%	66	91.67%	66	91.67%

Засаглал

Хувьцаа эзэмшигчид

Премиум Нэксус ХК-ийн засаглалын бүтэц нь Монгол Улсын холбогдох хууль, дүрэм журамд нийцсэн, үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлох, нөөц, дотоод хяналт, эрсдэлийг зөв зохистой удирдах, гүйцэтгэх удирдлагыг удирдан чиглүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн байдаг.


Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан Компанийн засаглалын кодекс болон олон улсад танигдсан шилдэг туршлага, зарчмуудыг баримталж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байгаа бөгөөд сайн засаглал нь бизнесийн стратегийг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, тэдгээрийн ашиг сонирхлыг хамгаалах, бизнесийн ёс зүй, ил тод, шударга байдлыг хангахад чухал үүрэг гүйцэтгэдэг хэмээн үздэг.

Хувьцаа эзэмшигчид ба хувьцаа

Компани нь олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох албан ёсны зөвшөөрлөө 2021 оны 10-р сарын 13-ны өдөр СЗХ-ноос авч 2021 оны 11-р сарын 03-ны өдөр Монголын хөрөнгийн бирж ХК дээр олон нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч арилжаагаа амжилттай дуусгаж, 2021 оны 11-р сарын 12-ны өдрөөс хоёрдогч зах зээлийн арилжаагаа эхэлсэн.

Мөн 2025 оны 11-р сарын 12-ны өдрөөр Компанийн нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдийн Компанид эзэмшиж буй хувь эзэмшил нь Компанийн нийт гаргасан хувьцааны 75 хувьд хүрсэн тул жижиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг Компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэхээр ТҮЗ шийдвэрлэсэн. Тус шийдвэрийн дагуу нэгж хувьцааг 350 төгрөгөөр авах саналыг гаргасан бөгөөд шаардах эрхийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийт **50,500,653** ширхэг хувьцааг Премиум Коммерс ХХК-аар дамжуулан худалдан авсан.

2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар нийт **9,518** хувьцаа эзэмшигчид Компанийн нийт гаргасан **1,114,252,034** ширхэг энгийн хувьцааг эзэмшиж байна.



Хувьцаа эзэмшигчдийн бүтэц (12/31/2025)

Хувьцаа эзэмшигчид	Тоо хэмжээ	Хувь
А. Ганхуяг	379,556,616	34.06%
А. Ганболд	263,375,296	23.64%
БиЖиЭф Ритэйл Ко., Лтд	92,600,479	8.31%
Ц. Баяржаргал	88,164,258	7.91%
Премиум Коммерс ХХК	50,500,653	4.53%
Бусад	240,054,732	21.54%
Нийт	1,114,252,034	100%

Төлөөлөн удирдах зөвлөл

ТУЗ нь хувьцаа эзэмшигч болон бусад оролцогч талуудад урт хугацааны үнэ цэнийг бий болгох зорилгоор хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхолд нийцүүлсэн үндсэн үйл ажиллагааны чиглэл, бодлого, стратегийг тодорхойлж, гүйцэтгэх удирдлагыг Компанийн зорилго, зорилт, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд удирдан чиглүүлж, хяналт тавин ажилладаг. ТУЗ нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй, гишүүдийн 6 нь ердийн, 3 нь хараат бус гишүүд юм.

ТУЗ-ийн цалин урамшуулал

2025 оны санхүүгийн жилд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд сарын 3-3.2 сая төгрөгийн цалин урамшуулал олгосон байна. ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын Компанид эзэмшиж буй хувьцааны тоон мэдээллийг доорх хүснэгтэд харуулав.

ТУЗ-ийн гишүүдийн Компанид эзэмшиж буй хувьцаа

(2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар)

ТУЗ-ийн гишүүд	Хувьцааны тоо ширхэг	Хувь
Гари Биондо (дарга, хараат бус)	-	-
А. Ганхуяг	379,556,616	34.06%
А. Ганболд	263,375,296	23.64%
Г. Чинзориг	6,842,227	0.61%
Г. Бат-Эрдэнэ	28,653,097	2.57%
Ч. Мөнхчимэг	-	-
Б. Бат-Эрдэнэ	-	-
Ө. Эрдэнэчимэг (хараат бус)	-	-
В. Ганзориг (хараат бус)	-	-

ТУЗ-ийн гишүүдийн сургалт, хөгжил

Компани нь ТУЗ-ийн гишүүнийг шинээр томилогдох бүрд Компанийн санхүүгийн тайлагнал, бизнесийн онцлог болон үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүний эрх, үүрэг, хариуцлага зэрэг мэдээллийг агуулсан танилцах хөтөлбөрт хамруулдаг.

ТУЗ-ийн гишүүд 2025 оны байдлаар Эмпасофт Академийн Мэдээллийн аюулгүй байдал, мэдээлэл технологийн MS365 сургалт, Баянзүрх консалтинг хуулийн нөхөрлөлийн Комплаенс, компанийн засаглал ба татварын төлөвлөлт сургалт болон Монголын банк бус санхүүгийн байгууллагуудын холбооны Комплаинс – Удирдах ажилтны манлайлал сургалтад хамрагдсан.

Төлөөлөн удирдах зөвлөл



Гари Стивен Биондо
ТУЗ-ийн дарга (хараат бус)

Гари Стивен Биондо (Gary Stephen Biondo) нь ТУЗ-ийн дарга (хараат бус) бөгөөд Улаанбаатар дах Олон Улсын Дүнд Сургуулийн ТУЗ-ийн дарга, Монгол дах АНУ-ын худалдааны танхим (АмЧам Монгол)-ын ТУЗ-ийн дарга, Эдельвайс Арт зочид буудлын гүйцэтгэх захирал юм. Тэрээр 36 гаруй жил зочид буудлын менежментийн салбарт, тэр дундаа ажилчдын сургалтын хөтөлбөр, Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын стандарт, чанар, дотоод хяналтын удирдлага, галын аюул, осол үүсэх эрсдэлийн удирдлагын тогтолцоог амжилттай хэрэгжүүлж, хяналт тавьж ажилласан туршлагатай. Гари Биондо нь Азийн өөр өөр соёл иргэншилтэй олон улс орнуудад өндөр зэрэглэлийн Шангри-Ла олон улсын зочид буудал, резортод 28 жил ерөнхий менежер, гүйцэтгэх удирдлагаар ажилласан бөгөөд АНУ-ын Колорадо мужийн Колорадо Коллежийг сонгодог уран зохиол, гүн ухааны чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Адилбишийн Ганхуяг
ТУЗ-ийн гишүүн

Адилбишийн Ганхуяг нь Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн бөгөөд сүүлийн 24 гаруй жил Монголын нэр нөлөө бүхий томоохон компаниуд болох М-Си-Эс Группийн Тэргүүн дэд ерөнхийлөгч, М-Си-Эс Холдинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, М-Си-Эс Кока-Кола ХХК болон Юнител ХХК-ийн ТУЗ-ийн дарга, Монголиан Майнинг Корпорацийн (НКЕХ: 975)-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү эрхэлсэн дэд ерөнхийлөгч, Улаанбаатар Хотын Худалдааны Танхимын Ерөнхийлөгчөөр ажиллаж ирсэн туршлагатай. Тэрээр эдгээр компаниудын үйл ажиллагааг олон улсын түвшинд хүргэх, таниулахад үнэтэй хувь нэмэр оруулж, эрчим хүч, уул уурхай, хөнгөн үйлдвэр, дэд бүтэц, барилга, худалдааны салбарт томоохон хэмжээний гадаадын хөрөнгө оруулалт татах ажлыг амжилттай удирдан зохион байгуулсан. А.Ганхуяг нь Монгол Улсын Их Сургуулийг санхүү, эдийн засгийн бакалавр, Квантик Бизнес, Технологийн Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.



Адилбишийн Ганболд
ТУЗ-ийн гишүүн

Адилбишийн Ганболд нь Премиум Корпорэйшний үүсгэн байгуулагч, Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал бөгөөд түүний зэргэлдээ, хараат компаниудын үйл ажиллагааг удирдан, стратегийн чиглэл, зорилтыг хэрэгжүүлэхэд тэргүүлэх үүрэг гүйцэтгэж ирсэн. Монгол Улсын авто зам барилга, хотын дэд бүтцийн компани болох Нэйшнл Девелопер ХХК-ийн Гүйцэтгэх захирал, тансаг зэрэглэлийн тавилга үйлдвэрлэгч Ганброс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд Ерөнхий захирлаар ажиллаж байсан. Түүний барилгын салбарын хөгжилд оруулж буй хувь нэмрийг төр засгаас өндрөөр үнэлж Алтан гадас одонгоор шагнасан юм. Тэрээр Оросын Холбооны Улсын Харьков хотын Барилгын дээд сургууль, Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль ("ШУТИС")-ийг цахилгаан тээвэр, системийн инженер мэргэжлээр суралцсан, бакалаврын зэрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөл



Гансүхийн Бат-Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн

Гансүхийн Бат-Эрдэнэ нь ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирал, Премиум Иннова ХХК-ийн ТУЗ-ийн гишүүн, Санхүү хариуцсан захирлаар ажилладаг. Тэрээр анхны ажлын гараагаа үйлдвэрлэл, худалдааны салбарт тэргүүлэгч М-Си-Эс Кока Кола ХХК-д санхүү төлөвлөлтийн газрын даргаар эхлүүлж байв. Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалт, уул уурхай, эрчим хүч, ажүлдвэрлэл, барилгын салбарт ажиллаж, Монголиан Майнинг Корпораци (НКЕХ: 975) болон Премиум Групп ХХК-ийн санхүүгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулсан бөгөөд М-Си-Эс Энержи ХХК-ийн дэд захирал, Монголиан Майнинг Корпорацийн Санхүү хариуцсан Дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байсан туршлагатай. Г.БатЭрдэнэ нь Хан-Уул Дээд Сургуулийг бизнесийн удирдлага, хэрэглээний математикч мэргэжлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



Чойжин-Осорын Мөнхчимэг
ТУЗ-ийн гишүүн

Чойжин-Осорын Мөнхчимэг нь ТУЗ-ийн гишүүн, Премиум Корпорэйшний Хүний нөөц хариуцсан захирал бөгөөд олон улсын томоохон төслүүдэд тооцогдох Оюу Толгой төсөл дэх Бетон зуурмагийн үйлдвэр, Салхин сэнсний төсөл, Шинэ нисэх онгоцны барилгын төсөл, Шангри-Ла зочид буудал, худалдааны төв төслүүдэд мэргэшсэн чадварлаг хүний нөөцийг бүрдүүлж, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн мэргэжилтнүүдийг бэлтгэн, төслүүдийг амжилттай хүлээлгэн өгөхөд үнэтэй хувь нэмэр оруулсан. Мөн тэрээр 2004-2012 онуудад үндэсний томоохон групп компани болох М-Си-Эс Групп болон Энержи Ресурс ХХК-ийн Ухаа худаг салбарт Захиргаа, хүний нөөцийн алба хариуцсан менежерээр ажиллаж байсан туршлагатай. Ч.Мөнхчимэг нь Удирдлагын Академийг төрийн захиргааны удирдлагын бакалаврын зэрэгтэй төгссөн.



Ганболдын Чинзориг
ТУЗ-ийн гишүүн

Ганболдын Чинзориг нь ТУЗ-ийн гишүүн, Премиум Нэксус ХК-ийн Гүйцэтгэх захирал юм. Тэрээр программ хангамж, бизнес процесс, бизнес интележенс, мэдээллийн технологийн мастер төлөвлөлт, инженерчлэлийн чиглэлээр ажилласан туршлагатай бөгөөд Мэдээллийн Технологи, Шуудан, Харилцаа Холбооны Газрын Бодлого төлөвлөлтийн газрын дарга, АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагт Эдийн засгийн бодлогын шинэчлэл ба өрсөлдөх чадварын төслийн мэдээллийн технологийн зөвлөх, Азийн Хөгжлийн Банкны Хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх төсөл, Хөрөнгийн зах зээлийн мэдээллийн систем ба санхүүгийн дэд бүтцийн зөвлөхөөр тус тус ажиллаж байсан туршлагатай. Тэрээр МТШХХГ-д ажиллаж байхдаа Цахим засаглал хөтөлбөрийн хэрэгжилтийг удирдан зохион байгуулж, Монгол Улсын Харилцаа холбоо, интернэт, шуудан, хэвлэл мэдээлэл, хиймэл дагуулын холбооны талаар баримтлах төрийн бодлого болон Мобайл сүлжээний 4G үйлчилгээг Монгол Улсад нэвтрүүлэх зохицуулалтын бодлогыг боловсруулсан. Г.Чинзориг нь ШУТИС-ийг компьютерын шинжлэх ухааны бакалавр, АНУ-ын Луисвиллийн Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн.

Төлөөлөн удирдах зөвлөл



Болдбаатарын Бат-Эрдэнэ
ТУЗ-ийн гишүүн

Болдбаатарын Бат-Эрдэнэ нь ТУЗ-ийн гишүүн, Польшийн Хөгжлийн Сангийн Хөрөнгө Оруулалт Худалдааны Агентлагийн Монгол дах суурин төлөөлөгч, Хорайзон Партнерс ХХК-ийн үүсгэн байгуулагч бөгөөд хөрөнгө оруулалт, олон улсын хамтын ажиллагаа, худалдааны чиглэлээр 17 гаруй жил ажилласан туршлагатай. Тэрээр Польш, АНУ, Швейцар улсад сурч, Монголын анхны гадаадын (Японы) хөрөнгө оруулалтын банканд зах зээлийн шинжээчээр, Олон Улсын Санхүүгийн Корпорац болон Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны хөрөнгө оруулалттай Монголын анхны хаалттай хөрөнгө оруулалтын санд (50 сая ам. долларын) зах зээл, бизнесийн шинжээчээр, Польш-Монголын хамтарсан худалдааны компанийн Гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан ба Азийн Хөгжлийн Банкны Монгол улсад "Private Equity" болон "Venture Capital" хөрөнгө оруулалтын сангийн зах зээлийг хөгжүүлэх техник эдийн засгийн үндэслэл боловсруулах зөвлөх компаниар ажилласан хөрөнгө оруулалт, стратеги, менежментийн зөвлөх үйлчилгээний компанийн үүсгэн байгуулагч юм. Б.Бат-Эрдэнэ нь Санхүү Эдийн Засгийн Их Сургуулийг нягтлан бодох бүртгэлийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.



Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Өлзийсүрэнгийн Эрдэнэчимэг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд нийгэм, эдийн засаг, хүрээлэн буй орчин, хөдөө аж ахуй, эрүүл мэндийн салбарт судалгаа, үнэлгээ хийх чиглэлээр мэргэшсэн Cognos International LLC компанийн Үүсгэн байгуулагч, Гүйцэтгэх захирлаар ажилладаг. Тэрээр НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP), НҮБ-ын Хүүхдийн Сан (UNICEF), НҮБ-ын Хүн Амын Сан (UNFPA), Азийн Хөгжлийн Банк (ADB), Дэлхийн Банк, ЮНЕСКО, Европын Холбоо зэрэг олон улсын байгууллагуудад болон Тогтвортой Хөгжлийн Зорилготой (SDGs) холбоотой засгийн газар, хувийн хэвшлийн хөтөлбөр, бодлогын хүрээнд 15 жил судалгаа, үнэлгээ, стратеги хөгжүүлэлтийн чиглэлээр ажиллаж байна. Эрдэнэчимэг нь Монголын үнэлгээний холбооны (MEA) Үүсгэн байгуулагч ба ТУЗ-ын дарга бөгөөд Америкийн үнэлгээний холбооны Нийгмийн нөлөөллийг хэмжих, Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) салбарын гишүүн, Олон улсын үнэлгээний хамтын ажиллагааны байгууллага (IOCE), Ази, номхон далайн үнэлгээний холбооны (APEA) үнэлгээг мэргэжлийн түвшинд хөгжүүлэх ажлын хэсгүүдийн гишүүн юм. Эрдэнэчимэг нь Лондонгийн Эдийн засгийн сургуулийг (LSE) Нийгмийн судалгааны арга зүйн Магистр, Тайландын Махидолын их сургуулийг Нөхөн үржихүйн эрүүл мэнд, хүн амын судалгааны магистр зэргээр тус тус төгссөн.



Ванчигийн Ганзориг
ТУЗ-ийн хараат бус гишүүн

Ванчигийн Ганзориг нь Премиум Нэксус ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд стратеги ба коммуникацийн чиглэлээр мэргэшсэн Бат Солюшн Партнерс ХХК-ийн Удирдах зөвлөлийн дарга, "CEO" клубийн ерөнхийлөгч, Монголын Дауны Холбоо, Менторшипийн залуу мэргэжилтнүүдийн хөтөлбөрийн тэргүүн, Монголын Тусгай Олимпын Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, "Global Teacher Prize"-ийн академийн гишүүн, Синдикат ярилцлага нэвтрүүлгийн модератор, тэргүүлэх мэдээллийн сайтуудын нийтлэлчээр ажилладаг. Тэрээр Худалдаа Хөгжлийн Банк, ХасБанк, МОСДАК, Шунхлай Группийн удирдлагын багт ажиллаж байсан туршлагатай бөгөөд Дэлхийн Эдийн Засгийн Форумын 2014 оны дэлхийн залуу манлайлагчаар шалгарсан. В.Ганзориг нь Японы Олон Улсын Их Сургуулийг цахим бизнесийн удирдлагын магистр, Австралийн Нотре Даме Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистрын зэрэгтэй төгссөн бөгөөд АНУ (Virginia, Yale), Англи (Oxford), Өмнөд Африк (WITS, Cape Town), Сингапур (NUS) улсуудад удирдлага, манлайлал, бодлогын инновац, гео улс төр, өөрчлөлтийн менежмент чиглэлээр мэргэжлийн сургалтуудад хамрагдсан Монголын Улсын мэргэшсэн зөвлөх юм.

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Тус компани нь Компанийн тухай хуулийн 81-д заасны дагуу ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулж үйл ажиллагааг нь хууль болон холбогдох журамд нийцүүлэн зохион байгуулж, тайлагнаж байна.

Мөн компанийн алсын хараа, олон улсын хандлага, туршлагыг нэвтрүүлэх үүднээс компанийн дээд удирдлага, бодлого, стратегийн түвшинд БОНЗ-ын хүрээний асуудалд анхаарч ТУЗ-ийн 2022 оны 07 тоот тогтоолоор Байгаль орчин, нийгэм, засаглалын хороог байгуулж гурав дахь жилдээ амжилттай ажиллаж байна. Тус хорооны хувьд компанийн стратегийн шилжилтийн хүрээнд “Хамтын үнэ цэн” гэсэн суурь ойлголтын дагуу шударга, хариуцлагатай, ил тод тунгалаг байх зарчмуудыг тодорхойлж хөрөнгө оруулагч болон оролцогч талуудад БОНЗ-ын тайлагналыг боловсруулан ажилласан байна.

БОНЗ-ын хорооны үндсэн чиглэл нь компанийн үйл ажиллагаа хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчинд, хүлэмжийн хийн ялгарал ба байгаль орчин компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, компанийн үйл ажиллагаа хүний эрх ба нийгэмд, хүний эрх ба нийгэм компанийн үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгаа, оролцогч талууд компанийн үйл ажиллагаа, компанийн соёлд хэрхэн нөлөөлж байгааг хянаж, удирдахаас гадна цаашдын бизнесийн тогтвортой, тасралтгүй байдлыг хангах, эрсдэлийн удирдлагыг илүү сайжруулах, хөрөнгө оруулагчдыг татахад чиглэнэ.

ТУЗ-ийн дэргэдэх хороонд хамрагдах гишүүд

ТУЗ-ийн дэргэдэх хороо	Гишүүдийн нэр	Албан тушаал
Байгаль орчин, нийгэм, эдийн засаглалын хороо	Ө. Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Ч. Мөнхчимэг	ТУЗ-ийн гишүүн
Нэр дэвшүүлэх хороо	В. Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
Цалин урамшууллын хороо	А. Ганхуяг	ТУЗ-ийн гишүүн
	Ө. Эрдэнэчимэг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хороо	А. Ганболд	ТУЗ-ийн гишүүн
	В. Ганзориг	Хорооны дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Гари Биондо	ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн хараат бус гишүүн
	Г. Бат-Эрдэнэ	ТУЗ-ийн гишүүн

ТУЗ-ийн дэргэдэх хороод

Байгаль орчин, нийгэм, засаглалын хороо

БОНЗ-ын хороо нь Компанийн байгаль орчин, нийгэм, засаглал (“БОНЗ”)–ын алсын хараа, стратеги, бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэхэд хяналт тавих; БОНЗ-ын шинээр гарч ирж буй чиг хандлага, асуудлуудыг хянаж үзэх, үүний дагуу Компанийн БОНЗ-ын талаарх алсын харааг боловсруулах, заавар зөвлөмжийг өгөх; аюулгүй байдал, байгаль орчныг хамгаалах, нийгмийн хариуцлага, компанийн засаглалын талаарх Компанийн бодлогыг тодорхойлох, түүнд шаардлагатай нэмэлт өөрчлөлтүүдийг оруулах; ТУЗ-ийн гишүүд болон гүйцэтгэх удирдлагын сургалт, тасралтгүй мэргэшлийн өсөлтөд хяналт тавих, хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагыг дагаж мөрдөх бодлого, журам, гарын авлага, ёс зүйн дүрмийг боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтийг хянах, ТУЗ болон түүний хороодын үйл ажиллагаа, ТУЗ-ийн гишүүдийн оруулсан хувь нэмрийг тогтмол үнэлж, ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. БОНЗ-ын хороо нь ТУЗ-ийн гишүүн Ч.Мөнхчимэг, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Эрдэнэчимэг, ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Ө.Эрдэнэчимэг нь тус хорооны дарга юм.

Цалин урамшууллын хороо

Цалин урамшууллын хорооны ТУЗ-ийн гишүүд, Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын цалин урамшуулал, нөхөн олговортой холбоотой зохицуулалтыг тодорхойлох, хяналт тавих, өндөр үр чадвартай ТУЗ болон гүйцэтгэх удирдлагыг үрт хугацаанд хадгалж ажиллуулах замаар хувьцаа эзэмшигчдийн ашгийг их байлгах ерөнхий зорилгын хүрээнд эдгээр эрх бүхий албан тушаалтнуудын урамшууллын хэлбэр, хэмжээ нь зохистой байгаа эсэхийг хөдөлмөрийн зах зээлийн холбогдох нөхцөл байдалд үндэслэн үнэлэх үүрэгтэй юм. Цалин урамшууллын хороо нь ТУЗ-ийн гишүүн А.Ганболд, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Эрдэнэчимэг, ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд Ө.Эрдэнэчимэг нь тус хорооны дарга юм.

Аудитын хороо

Байгууллагад үр дүнтэй дотоод хяналтын тогтолцоог бий болгох буюу бизнесийн үр ашигтай захиран зарцуулах дотоод хяналтыг хэрэгжүүлэх, Компанийн эд хөрөнгийг хамгаалах, нягтлан бодох бүртгэлийн зохих бүртгэл хөтлөх, санхүүгийн мэдээллийн үнэн зөв, найдвартай байдлыг хангах, түүнчлэн үйл ажиллагааны гол үзүүлэлтүүдийг харьцуулах зэрэг санхүүгийн бус асуудлуудтай холбоотой бизнесийн удирдлагын дотоод хяналтын тогтолцоо, ёс зүйн хэм хэмжээг бий болгох, хадгалахад чиглэсэн санал зөвлөмжийг ТУЗ-д гаргах үүрэгтэй. Аудитын хороо нь ТУЗ-ийн гишүүн Г.Бат-Эрдэнэ болон ТУЗ-ийн хараат бус гишүүн болох В.Ганзориг, ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.

Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн сул орон тоог нөхөх Компанид шаардлагатай мэдлэг, үр чадвартай нэр дэвшигчдийг олж тодорхойлох, тэдгээрийг ТУЗ-д танилцуулах, санал, зөвлөмж гаргах үүрэгтэй. Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн гишүүн А.Ганхуяг, ТУЗ-ийн хараат бус гишүүн В.Ганзориг, ТУЗ-ийн дарга (хараат бус) Гари Биондо нараас бүрдсэн гурван гишүүнтэй бөгөөд В.Ганзориг нь тус хорооны дарга юм.

ТУЗ-ийн хурлын үйл ажиллагаа

ТУЗ нь 2025 онд нийт 5 удаа хуралдсан бөгөөд 2025 онд нийт 52-н шийдвэр, тогтоол гарган баталгаажуулж ажилласан байна. Хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын агуулгуудын хүрээнд Компанийн 2024 оны санхүүгийн гүйцэтгэл, жилийн эцсийн үйл ажиллагааны тайлан, Компанид эзэмшиж буй энгийн хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг Компаниас шаардах эрхийг хэрэгжүүлэх, тайлант хугацаанд Компани болон охин компаниудын үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагын болон компанийн засаглалын дотоод асуудлууд, сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх зөвшөөрөл олгох, ногдол ашиг хуваарилах эсэх зэрэг төрөл бүрийн асуудлуудыг хэлэлцэн, шийдвэр тогтоол гарган ажилласан.

Үйл ажиллагаа	2021	2022	2023	2024	2025
ТУЗ хуралдсан тоо	5	7	4	4	5
Хурлаар хэлэлцсэн асуудлын тоо	24	37	39	43	52
Хурлын ирц	100%	100%	100%	100%	100%
Хараат бус гишүүдийн хурлын ирц	100%	100%	100%	100%	100%

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга

2025 онд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ болон ТУЗ-ийн хороодод засаглалын асуудлаар зөвлөгөө, мэдээлэл өгөх, Компанийн бодлогын баримт бичиг, дотоод журмын хэрэгжилтэд хяналт тавих, Компанийн хувьцаа эзэмшигчид, ТУЗ, ТУЗ-ийн хороод болон охин компаниудын ТУЗ-өөс гарах тогтоолын төслийг боловсруулах, хурлыг зохион байгуулах, хурлын тэмдэглэл хөтлөх, ТУЗ-ийн гишүүдийн сургалтыг зохион байгуулах, Компанийн үнэт цаас, түүнийг эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх, төрийн зохицуулах болон үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо, хадгаламжийн байгууллагатай харилцах зэрэг ажлыг хийж гүйцэтгэснээс гадна Компани болон охин компаниудын хүрээнд батлагдсан бодлогын баримт бичгийг олон улсын стандарт, олон улсад түгээмэл ашиглагддаг гэрээ конвенцэд тусгасан агуулгаар тодорхойлох, Компанийн засаглал, эрсдэлийн удирдлага, комплайнсын тогтолцооны хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход шаардлагатай мэдээллийг цуглуулж, зөрүүний шинжилгээ хийсэн бөгөөд цаашид нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх, санал, зөвлөмж боловсруулах, ТУЗ болон ТУЗ-ийн хороодын үйл ажиллагааг үр дүнтэй явуулах ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөөд байна.

Эрх бүхий албан тушаалтан

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, Гүйцэтгэх захирал, Санхүү хариуцсан захирал, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал нь Компанийн эрх бүхий албан тушаалтнууд юм. Компанийн эрх бүхий албан тушаалтнуудад 2025 онд олгосон сарын цалин урамшууллын хэмжээг татварын өмнөх үнийн дүнгээр багцлан доорх хүснэгтэд харуулав.

Сарын үндсэн цалингийн хэмжээ (төгрөг)	Хэмжих нэгж
10,000,001 болон түүнээс дээш	6
5,000,001 - 10,000,000	0
0 - 5,000,000	5

Тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулж буй хувь нэмэр

Нэгдсэн Үндэстний Байгууллагын санаачлан хэрэгжүүлж буй Тогтвортой хөгжлийн зорилго (ТХЗ) нь хүн төрөлхтөнд илүү сайхан, тогтвортой ирээдүйд хүрэхийн тулд хөгжлөөс хэнийг ч үл хоцроож, үлдээхгүйн төлөө чин эрмэлзэлд тэмүүлсэн дэлхий нийтийн, хамтын хүчин чармайлт юм. Даян дэлхийн улс орон бүр амлалт өгсөн ТХЗ-н баримт бичиг нь 17 зорилго, 169 зорилтын хүрээнд ядуурал, тэгш бус байдал, уур амьсгалын өөрчлөлт, байгаль орчны доройтол, энх тайван, шударга ёс зэрэг сорилтуудыг авч үздэг. ТХЗ-ийг биелүүлэхэд бүх оролцогч талуудын үүрэг амлалт, хүчин чармайлт чухал бөгөөд Премиум Нэксус ХК нь бизнесийн стратеги, бүтээгдэхүүн, үйлчилгээгээр дамжуулан хамгийн их нөлөө үзүүлж чадна гэж үзэж буй өөрийн ТХЗ-уудыг тодорхойлсон.

ТХЗ	Хувь нэмэр
	2025 оны байдлаар бид 100 шинэ салбар дэлгүүр нээж, ажлын байр үүсгэн, 16 бүс нутгуудад үйл ажиллагаагаа тэлж, Улаанбаатар хотод 443, орон нутагт 102, нийт 545 салбар дэлгүүртэйгээр үйл ажиллагаа явуулж байна.
	2025 онд нийт 545 гаруй салбар дэлгүүрээр өдөр бүр 200,000 гаруй үйлчлүүлэгч үйлчлүүлж, 100,000 гаруй ширхэг бэлтгэсэн хоол борлуулсан бөгөөд сүлжээ дэлгүүрийн хэмжээнд борлуулагдаж буй нийт хоолны 44,8 хувийг CU хоолны үйлдвэрт үйлдвэрлэдэг бол 55.2 хувийг дотоодын хоол үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийлүүлдэг байна.
	2025 онд Премиум Нэксус ХК-ийн хувьд нийт 20 хоол бэлтгэн нийлүүлэгчтэй хамтран ажиллаж байгаа ба нийт нийлүүлэгчийн 85% нь НАССР баталгаажилт орсон байна. <ul style="list-style-type: none"> 17 нийлүүлэгч НАССР стандартыг хэрэгжүүлж баталгаажилтын гэрчилгээ авсан Үлдсэн 3 нийлүүлэгч НАССР хэрэгжүүлэхээр төлөвлөн ажиллаж байна. 2026 оны эхний улиралд нийт нийлүүлэгчийн 90 хувь нь НАССР стандарт хэрэгжүүлсэн байхаар төлөвлөн ажиллаж байна.
	<ul style="list-style-type: none"> 2025 оны "Залуучуудад ээлтэй ажил олгогч" - оор шалгарав. 2024-2025 онд сургалтын баг 23,852 ажилтанд 129,158 хүн цагийн сургалтыг 840 гаруй удаагийн давтамжтай хүргэжээ. 2024-2025 онд сургалтад суусан ажилтнуудаас 1,321 ажилтан карьер зэрэглэл хөндлөн чиглэлд ахисан бол босоо чиглэлд 412 хүн албан тушаал дэвшсэн.

ТХЗ	Хувь нэмэр
	2025 оны тоо баримтаас харахад Премиум Нэксус ХК-ийн нийт ажилтнуудын 70,5% нь эмэгтэй, 29,5% нь эрэгтэй байна. Удирдлагын түвшин дэх хүйсийн харьцааг авч үзвэл эмэгтэй ажилтны эзлэх хувь анхан, дунд удирдах түвшинд 50%, гүйцэтгэх удирдлагын түвшинд эрэгтэй ажилтны эзлэх хувь 53.3% байна. Эрэгтэй, эмэгтэй ажилчдын цалингийн харьцаа бүх түвшинд 1:1 байна.
	CU 545 салбараар эрүүл ахуйн шаардлага хангасан ариун цэврийн үйлчилгээгээр хангаж, ус хэмнэх мэдрэгчтэй угаалтуур болон суултуурын усны таталтыг 50% -р бууруулсан арга хэмжээ авсан. Үйл ажиллагаандаа ус хэмнэлттэй технологийг суурилуулах арга хэмжээг авснаар 1 сая төгрөг тутам дах борлуулалтад ноогдох усны хэрэглээг өмнөх жилээс 31 литрээр бууруулж чадлаа.
	Эрчим хүчний хэрэглээг БОНЗ суурь жил болох 2020 онтой харьцуулахад 1 сая төгрөгийн борлуулалт хийхэд зарцуулдаг эрчим хүчний хэрэглээ 2.9 дахин буурсан байна.
	Богиносгосон эсвэл бүтэн цагаар хөдөлмөр эрхэлж буй оюутан залуучууд 50 гаруй хувийг эзэлж байгаа бөгөөд дийлэнх олонх нь 18-34 насны залуучууд байна. Компанийн зүгээс ажилтны аюулгүй байдлыг хангахад чиглэсэн олон арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд: Бүх дэлгүүрийг камержуулж, салбар дэлгүүрүүдэд гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө боловсруулж, галын тохижилтын арга хэмжээ авч ажилласан. Харуул хамгаалалтын компанитай гэрээ байгуулж хамгаалалт дуудах товчийг дарснаас хойш 10 минутын дотор хамгаалалтын баг ирдэг. CU хоолны үйлдвэр, 2 түгээлтийн төвүүдийн ажилтнууд, оффисын 7 хоног бүр гадуур тогтмол явдаг ажилтнууд гэнэтийн ослын даатгалд хамрагддаг. ХАБЭА сургалт, спортын тэмцээнийг тогтмол зохион байгуулдаг бөгөөд нэг бүрийн хамгаалах хэрэгслээр тогтмол хангадаг.

Тогтвортой хөгжлийн зорилтуудад оруулж буй хувь нэмэр

ТХЗ Хувь нэмэр



1. Нийт 830,000 бүртгэлтэй хэрэглэгч, өдөр тутмын 200,000 идэвхтэй хэрэглэгчтэйгээр хөгжиж буй CU аппликэйшнийг хөгжүүлсэн.
2. CU нийлүүлэгчдийн Vendor Portal, ажилтнуудын Employee Portal, хүргэлтийн захиалга хүлээн авах бүртгэх систем, үйл ажиллагааны үндсэн системүүдийн хоорондын интеграцийн хөгжүүлэлт болон байнгын хэвийн ажиллагаа, нэмэлт сайжруулалтыг хангаж ажиллан, Монголын хэрэглэгчдэд дэвшилтэт технологийн шийдлүүдийг хүргэсээр байна.
3. Stora V2.0 Үүсгэн байгуулагдсаны 3 жилийн ойгоо угтан Стора Централ ХХК нь системийн бүрэн шинэчлэлтээ хийн V2.0 хувилбараа танилцуулав. Уг шинэчилсэн хувилбар нь хэрэглэгчид илүү ойлгомжтой дизайн, процесс болон хэрэглэгчдийн эрэлт хүсэлтэд нийцсэн цоо шинэ 6 дэлгүүр болох Ikea, Apple, Costco, Sephora, Nike, Victoria Secret-ийг нэгтгэв.



2025 оны байдлаар Премиум Нэксус ХК-д хөгжлийн бэрхшээлтэй ажилтан нийт үндсэн ажилтны 8,9%-ийг эзэлж байгаа нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.2 дах заалт буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар ажил олгогчид тавьдаг үүрэгтэй бүрэн нийцэж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу богиносгосон цагаар ажилладаг. Ажлын байрны зарыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй түгээх үүднээс хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбоонуудтай хамтарч ажилладаг.



Насанд хүрээгүй хүүхдэд насны хязгаарлалттай бүтээгдэхүүн болох электрон болон утаат тамхи, согтууруулах ундаа худалдан авахаас урьдчилан сэргийлж иргэний бичиг баримтыг шалган худалдаалахад уриалсан “Үзүүлээд Өгье” аяныг хэрэгжүүлсэн.

“Соёл танаас эхэлнэ” нийгмийн аяныг Цагдаагийн Ерөнхий Газар CU болон GS25-тай хамтран амжилттай хэрэгжүүлсэн. Энэхүү аян нь нийтийн соёл ёс суртахууныг дээшлүүлж, илүү эелдэг, бусадтай илүү хүндэтгэлтэй харилцдаг сайхан нийгмийг бүтээхэд олон нийтийг уриалсан бөгөөд давхардсан тоогоор 65,278,300 хүнд хүрсэн томоохон аяны нэг болсон.



Стора Централ ХХК нь Тогтвортой хөгжлийн 17 зорилгын хүрээнд StoreForGood төслийг эхлүүлж, хог хаягдлыг багасгах, байгальд ээлтэй хэрэглээг дэмжих зорилготой ажиллаж байна. Уг төсөл нь хүмүүсийн хамгийн дутуу хэрэглэн хаядаг, хэрэгцээгүй худалдан авалт их хийдэг, үйлдвэрлэх нөөц болон байгальд шингэх хор хөнөөл ихтэй бүтээгдэхүүнийг хоорондоо солилцон хэрэглэх замаар насыг нь уртасгаж хог хаягдлыг багасгах зорилготой бөгөөд стора.мн болон сторабоксын дэд бүтцийг ашиглан ном, хүүхдийн тоглоом, хувцас зэрэг эд зүйлсийг солилцох боломжийг олгодог. Цаашид солилцох бүтээгдэхүүний хүрээг нэмэгдүүлж, хэрэглээг уртасгах, эд хэрэгслийн хор хөнөөлийг бууруулах шинэ трендийг хөгжүүлэхээр зорьж байна.

ТХЗ Хувь нэмэр



2025 онд хүргэлтийн үйлчилгээг өглөөний 04:00-08:00 цагийн хооронд тээвэрлэх үйл ажиллагааг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна. Хотын зүүн хэсэгт байрлах хүйтэн хэлхээний түгээлтийн төвөөр дамжуулан хөргүүр бүхий машинаар өдөр бүр 80,000-100,000 хүнсний бүтээгдэхүүнийг, баруун өмнөд хэсэгт байрлах ердийн түгээлтийн төвөөс энгийн ачааны машинаар өдөр тутмын хүнсний бүтээгдэхүүнийг салбар дэлгүүрүүдэд хүргэж байна.

Энэхүү хүргэлтийн хөдөлгөөний зохицуулалтын үр дүнд тээврийн хэрэгслийн зорчих хөдөлгөөний тоог эрс багасгаж, түгээлтийн цагаа түгжрэлгүй үеэр зохион байгуулснаар тээвэрлэлтийн хугацааг 4 дахин богиносгож, шатахуун зарцуулалтыг 80%-иар бууруулан, агаарын бохирдол болон хүлэмжийн хийн ялгарлыг мэдэгдэхүйц багасган ажиллаж байна.



Дэлгүүр бүрд төрөлжүүлсэн хогийн сав байрлуулж, хоолны хаягдлыг гахайн фермд, ашигласан тосыг савангийн үйлдвэрт, цаасан хайрцаг рулоныг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлдэг. Бусад дахин ашиглагдах боломжгүй хог хаягдлыг гэрээт тохижилт үйлчилгээний компаниуд долоо хоног бүр ачиж, ариутгал халдваргүйжүүлэлт тогтмол хийдэг.



Зээлийн батлан даалтын сан нь Капитрон банк, Премиум Нэксус ХК-тай хамтран CU конвينيенс дэлгүүрийн франчайз эрхийг хөнгөлөлттэй, батлан даалттай зээлээр авах боломжийг бүрдүүлэн ажиллаж байна. 2025 оны байдлаар нийт 32 бизнес эрхлэгч эмэгтэйд 3.4 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. Жилийн 8.88%-ийн хүүтэй, 140 сая хүртэлх төгрөгийн зээл нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд богино хугацаанд хувийн бизнесээ эхлүүлэх, өргөжүүлэх боломжийг олгож, жендерийн тэгш байдлыг хангахад чиглэсэн томоохон алхам болж байна. Энэхүү түншлэл нь Монголын уламжлалт бизнесийн хэв маягийг өөрчилж, эмэгтэйчүүдийн манлайллын шинэ жишиг тогтоон, 2024 оноос эхлэн орон нутгийн эмэгтэй бизнес эрхлэгчдэд зээлийн хүртээмжийг нэмэгдүүлэн ажиллаж байна.

Хавсралт

	Огноо (он, сар, өдөр):	2026 оны 04 сарын 26
1	Үнэт цаас гаргагчийн нэр:	Премиум Нэксус ХК
2	Үнэт цаас гаргагчийн код (МХБ симбол):	CUMN
3	Салбар/үйлдвэрлэл (МХБ-ийн салбарын ангилал):	Худалдаа
4	Тайланд орсон компаниуд (энэхүү тайланд орсон толгой болон охин компаниудын мэдээлэл):	Премиум Нэксус ХК, Сэнтрал Фүүдс ХХК, Сэнтрал Коммерс ХХК, Чингис Шар айраг ХХК, Стора Централ ХХК, Сэнтрал Кофе Рөүстинг ХХК,
5	Тайлангийн хамрах хугацаа:	2025 оны 1 сарын 1 – 2025 оны 12 сарын 31
6	Хариуцсан албан тушаалтны овог нэр, албан тушаал, холбоо барих имэйл хаяг, утас:	Г.Пүрэвхүү Премиум Нэксус ХК-ийн Байгаль орчин зөвлөх purevkhuu.g@cumongol.mn
7	Тайланг баталгаажуулсан Гүйцэтгэх захирал, ТУЗ-ын даргын мэдээлэл (нэр, албан тушаал):	ТУЗ-ын гишүүн (хараат бус) , ТУЗ-ын дэргэдэх БОНЗ-ын хорооны дарга Ө.Эрдэнэчимэг erdenechimeg.u@cumongol.mn

Код	Огноо (он, сар, өдөр):	Ангилал	Тайлбар	Үзүүлэлт, хэмжих нэгж
MS1.1	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Удирдлагын амлалт	Удирдлагаас баталсан тогтвортой хөгжлийн амлалт/мэдэгдэл байдаг эсэх	Тийм
MS2.1		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн бодлого, зорилтуудыг тодорхойлж баталсан эсэх	Тийм
MS2.2		Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Тогтвортой хөгжлийн журам байдаг эсэх	Тийм
MS3.1		Бүтэц удирдлага	Танай компани тогтвортой хөгжлийн асуудал хариуцсан хороо байдаг эсэх	Тийм
MS3.2		Бүтэц удирдлага	ТҮЗ-ийн түвшинд тогтвортой хөгжил / БОНЗ-ын асуудал хариуцсан гишүүн (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм
MS3.3		Бүтэц удирдлага	Гүйцэтгэх удирдлагын түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан менежер (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм
MS3.4		Бүтэц удирдлага	Үйл ажиллагааны түвшинд тогтвортой хөгжил/ БОНЗ-ын асуудал хариуцсан албан тушаалтан (бүтэн цагийн/хавсран) байдаг эсэх	Тийм
MS3.5		Бүтэц удирдлага	Танай компани ТҮЗ-ийн хурлын хөтөлбөрт тогтвортой хөгжлийн асуудлыг албан ёсоор тогтмол тусгадаг уу?	Тийм
MS4.1		Тогтвортой байдлын нөлөөллийн үнэлгээ	Танай компани эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, бууруулах, арилгах, эерэг үр нөлөөг сайжруулах талаар тайлбарласан нөлөөллийн процесс, үнэлгээ эсвэл матриц байдаг эсэх	Тийм
MS5.1		Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтанд ногдох тогтвортой хөгжлийн тухай сургалтын жилийн дундаж цаг, хүйсээр	2.7 цаг
MS6.1		Хяналт	Тогтвортой байдлын асуудал нь аудитын хорооны үйл ажиллагаа, дотоод хяналтын чиг үүрэгт хамаардаг уу?	Тийм
MS7.1		Тогтвортой байдлын тайлагнал	Танай компани тогтвортой байдал/ хөгжлийн тайлан (жилийн тайланд нэгтгэдэг эсвэл тусдаа тайлан)-гаа жил нэгээс доошгүй удаа тайлагнадаг уу?	Тийм

MS7.2		тайлагнал	Танай компани уур амьсгалын эрсдэлийг олон улсын стандарт (УАӨСМТАХ, БОТСМТАХ)-ын дагуу тайлагнадаг уу?	Тийм
MS7.3	Тогтвортой хөгжлийн удирдлагын систем	Тогтвортой байдлын тайлагнал	Тогтвортой хөгжлийн болон БОНЗ-ын мэдээллийг хөндлөнгийн байгууллагаар баталгаажуулдаг уу?	үгүй
MS8.1		Гишүүнчлэл, хамтын ажиллагаа	Танай компани тогтвортой хөгжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон улсын болон дотоодын холбоо, нэгдэлтэй нэгдэж хамтран ажилладаг уу? Үүнд, хүний эрх болон бизнесийн тунхаглал орно.	Тийм
E	Байгаль орчны шалгуур үзүүлэлтүүд			
E1.1	Эрчим хүч	Нийт эрчим хүчний хэрэглээ	Эрчим хүчний нийт зарцуулалтын хэмжээ болон зардал	35,615,662 кВт.ц
E1.2		Цахилгаан	Цахилгааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	32,736,224 кВт.ц
E.13		Дулаан	Дулааны нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр)	2,879,438 кВт.ц
E.14		Түлш	Түлшний нийт зарцуулалтын хэмжээ болон хэмнэлт (жилээр). Үүнд, 1. Халаах зорилгоор хэрэглэсэн түлш буюу нүүрс, хий 2. Тээврийн зардалд ашигласан түлш буюу бензин, дизель	219.020 тн дизель 329.17 тн сайжруулсан нүүрс 13461 л газ 329.17 тн сайжруулсан нүүрс 13461 л газ 219.02 тн түлш
E1.5		Хүрэн эрчим хүч	СЭХ-ээс бусад эх үүсвэрээс авсан эрчим хүчний хэрэглээний хувь	100%
E1.6		Сэргээгдэх эрчим хүч	СЭХ үүсвэрээс гаргаж авсан эрчим хүчний хэрэглээний хувь	0%
E2.1	Хүлэмжийн хийн ялгарал	3.1 Хүлэмжийн хийн ялгаруулалт	Компанийн шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан нийт хүлэмжийн хийн дүн	29,218,72 тн CO2eq

E2.2		3.2 Бүүруулсан хүлэмжийн хий	Байгууллагын шууд ба шууд бус үйл ажиллагаанаас ялгарсан хүлэмжийн хийн нийт дүн (жилээр)	тайлагнах боломжгүй
E2.3		3.3 Дүйцүүлэх арга хэмжээ /Карбон офсет/	Нийт карбон офсет буюу дүйцүүлэх арга хэмжээний (мод тарих хөтөлбөр, эсвэл хүлэмжийн хийг бууруулах гаднын төслийг дэмжих гэх мэт) бууралт	тайлагнах боломжгүй
E3.1	Уур амьсгалын өөрчлөлт	Уур амьсгалын бодлого, журам	Танай компани уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тусдаа эсвэл бусад журамд тусгасан бодлоготой юу?	үгүй
E3.2		Уур амьсгалын эрсдэл ба боломжийн үнэлгээ	Танай компани уур амьсгалын эрсдэл, боломжийн талаарх үнэлгээ хийсэн үү? (сценарийн шинжилгээ, стресс тест гэх мэт)	үгүй
E3.3	Эрчим хүч	Эдийн засгийн хохирол	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшиг, үйл явдлын улмаас учирсан эдийн засгийн нийт хохирлын хэмжээ	тайлагнах боломжгүй
E3.4		Уур амьсгалын хөрөнгө оруулалт	Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дэд бүтэц, дасан зохицол, бүтээгдэхүүн хөгжилд оруулсан нийт хөрөнгө оруулалтын дүн	тайлагнах боломжгүй
E3.5		Уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэх эсвэл дасан зохицох	Уур амьсгалын өөрчлөлттэй холбоотойгоор танай компанийн ашигт ажиллагаа эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарт нөлөөлөх эрсдэлээс урьдчилан сэргийлэх, (хэрэв урьдчилан сэргийлэх боломжгүй бол) дасан зохицох чиглэлд хэрэгжүүлэх арга хэмжээ/алхмуудыг тодорхойлсон үү?	үгүй
E4.1	Ус	Усны хэрэглээ	Ашигласан усны нийт хэмжээ	357,355 м3
E4.2		Хэмнэсэн ус	Хэмнэлт, үр ашгийг дээшлүүлснээр нийт хэмнэсэн/дахин боловсруулсан усны хэмжээ	тайлагнах боломжгүй
E4.3		Дахин боловсруулсан ус	Дахин ашигласан болон боловсруулсан усны эзлэх хувь	0%
E4.4		Хаягдал бохир ус цэвэрлэх	Цэвэрлэсэн нийт хаягдал бохир усны хэмжээ	тайлагнах боломжгүй
E5.1	Хатуу хог хаягдал	Хог хаягдал	Нийт ялгаруулсан хог хаягдлын хэмжээ	2700 тн
E5.2	Хүлэмжийн хийн ялгарал	Дахин боловсруулсан хатуу хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулсан хувь	50.69%
E5.3		Хортой хог хаягдал	Хортой хог хаягдлын нийт хэмжээ (Үүнд цахилгаан хэрэгслийн хог орно)	тайлагнах боломжгүй

E6.1	Биологийн олон янз байдал	Ногоон байгууламж, төлөвлөлт	Байгаль орчны хувьд тогтвортой ашиглаж буй нийтийн эзэмшлийн талбай буюу барьсан ногоон байгууламжийн талбайн нийт талбайд эзлэх хувь	16%
E6.2		Зэрлэг ургамал, амьтдыг хамгаалах	Хамгаалсан төрөл зүйлийн тоо	байхгүй
E6.3	Үүр амьсгалын өөрчлөлт	Биологийн олон янз байдалд сөргөөр нөлөөлж буй үйл ажиллагаа	Тусгай хамгаалалттай газар нутаг, биологийн олон янз байдал, соёлын үнэ цэнэ өндөртэй газар нутгийг эзэмшиж, түрээсэлсэн, удирдаж байгаа эсвэл зэргэлдээх үйл ажиллагааны талбайн нийт талбайд эзлэх хувь	байхгүй
S	Нийгмийн шалгуур үзүүлэлтүүд			
S1.1	Хүний нөөц	Хүний нөөцийн тогтвортой байдал	Үндсэн ажилтнуудын ажлын байрны сэлгээний хувь (тухайн онд ажлаасаа гарсан ажилтнуудын тоог ажилласан ажилтнуудын дундаж тоонд хуваах)	16%
S1.2		Шинээр бий болгосон ажлын байр	Өмнөх оны мөн үеэс нэмэгдсэн бүтэн цагийн ажлын байрны тоо	803
S1.3		Сургалт	Нэг ажилтанд ногдох жилийн дундаж сургалтын цаг	2.7
S2.1	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (ХАБЭА)	ХАБЭА-н бодлого	ХАБЭА-н бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм
S2.2		Осол аваар	Үйл ажиллагааны явцад гарсан хөдөлмөрийн чадвар алдалтад хүргэсэн гэмтлийн давтамж	0
S2.3		ХАБЭА-н сургалт	Жилд нэг ажилтанд ногдох дундаж ХАБЭА сургалтын цаг	2.7 цаг
S2.4		Эрүүл мэндийн хөтөлбөр	Эрүүл мэндийн үзлэг зэрэг сайн дурын эрүүл мэндийн үйлчилгээнд хамрагдсан ажилчдын тоо, жилээр	1048
S3.1	Эрх тэгш байдал	Жендерийн бодлого, журам	Жендерийн бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	үгүй
S3.2		Ажлын байрны бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам	Бэлгийн дарамтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм
S3.3		Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам	Ялгаварлан гадуурхалтын эсрэг бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм

S3.4		Ажилтнуудын хүйсийн харьцаа	Нийт үндсэн ажилтнуудын тоонд эрэгтэй, эмэгтэй ажилтны эзлэх хувь	Эр-28% Эм-72%
S3.5		Удирдах зөвлөлийн хүйсийн харьцаа	Удирдах зөвлөлийн гишүүдийн эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-78% Эм-22%
S3.6		Гүйцэтгэх удирдлагын хүйсийн харьцаа	Гүйцэтгэх удирдлагын түвшний ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-53% Эм-47%
S3.7		Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын хүйсийн харьцаа	Дунд болон анхан шатны нэгжийн ажилтнуудын эрэгтэй, эмэгтэй хүйсийн харьцаа	Эр-30% Эм-70%
S3.8		Жендерт суурилсан цалингийн зөрүү	Эрэгтэй ба эмэгтэй ажилтнуудын дундаж цалингийн харьцаа	Эмэгтэй/ Эрэгтэй=1:1
S4.1	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бодлого, журам	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан олон нийтэд нээлттэй бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	Тийм
S4.2		Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнууд	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын нийт ажилтны тоонд эзлэх хувь	4%
S4.3		Оффисын хүртээмж	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй байдлаар шийдсэн оффис, байгууламжтай юу	Үгүй
S4.4		Торгууль	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах тухай хууль тогтоомжийг дагаж мөрдөөгүйн улмаас төлсөн торгуулийн хэмжээ	0
S5.1	Нийгмийн хариуцлага ба олон нийтийн оролцоо	Оролцогч талуудын оролцооны засаглал	Оролцогч талуудтай хамтарч ажиллах талаар тусгайлсан бодлого байгаа юу?	тийм
S5.2		Нийгмийн нөлөөллийн үнэлгээ, газар чөлөөлөлтийн бодлого журам	Танай компани нийгэмд нөлөөлөх байдлын бодлого, журамтай юу? (Үүнд газар чөлөөлөлт багтана)	байхгүй
S5.3		Санал гомдлыг шийдвэрлэх бодлого/ журам	Гомдол маргааныг шийдвэрлэх бодлого, механизм бий юу?	тийм

S5.4		Олон нийтэд ил тод мэдээлэх	Танай компанийн үйл ажиллагаа нөлөөлж буй иргэдэд мэдээлэл өгөх, санал хүсэлт авч, гомдол шийдвэрлэх тогтолцоо бий юу?	тийм
S5.5		Ажилчид/олон нийтийн санал гомдол	Ажилчид болон олон нийтээс ирсэн санал гомдлыг шийдвэрлэсэн хувь	100%
S5.6		Нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө оруулалт	Нийгмийн хариуцлагын арга хэмжээ, хөтөлбөрт зарцуулсан хөрөнгө оруулалтын нийт орлогод эзлэх хувь, ТХЗ-оор ангилсан	тайлагнах боломжгүй
S6.1	Тогтвортой өртгийн сүлжээний менежмент	Худалдан авалтын бодлого, журам	Танай компанид дотоодын худалдан авалт болон тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн эрсдэл боломжийг хангасан худалдан авалтын бодлого, журам бий юу (тусдаа бодлого журам эсвэл аль нэг журамд нэгтгэсэн)?	тийм
S6.2		Дотоодын худалдан авалт	Дотоодын ханган нийлүүлэгчдээс авсан худалдан авалтын хувь	97%
S6.3			Нийт ханган нийлүүлэгчдийн тоонд тогтвортой буюу байгаль орчин, нийгмийн шалгуураар сонгогдсон ханган нийлүүлэгчдийн хувь	тайлагнах боломжгүй
G	Засаглал			
G1.1	Компанийн засаглал	Компанийн засаглалын бодлого, журам	Шинээр батлагдсан Кодексийн дагуу компанийн засаглалын бодлого, журам бий юу, уг журмын тайлагнал хийдэг үү?	тийм
G1.2		Удирдах зөвлөлийн хараат бус байдал	Удирдах зөвлөлд хараат бус гишүүдийн суудлын хувь	33.33% (1/3)
G1.3		Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх	Цөөнх, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах дүрэм, журам бий юу?	тийм
G2.1	Авлигал болон ёс зүй	Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого журам	Авлигын эсрэг эсвэл Ёс зүйн бодлого, журам бий юу?	тийм
G3.1	Комплаенс	Комплаенсын бодлого	Комплайнсын бодлого, журам бий юу?	тийм
G3.2		Комплаенсын хөтөлбөр	Комплайнсын хөтөлбөр, журам (ажилчдын сургалт, аудит, хяналтын систем, зөрчлийн талаар мэдээлэх, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх удирдамж, хориг гэх мэт) бий юу?	тийм
			Салбарын онцлогтой нэмэлт шалгуур үзүүлэлтүүд (зөвхөн өөрийн компанид хамаарах салбарын асуултад хариулна)	
AF1	Хөдөө аж ахуй & хүнсний үйлдвэрлэл	Устгалын бодис	Танай компанид хортон шавж устгалын бодисын хэрэглээг зохицуулах бодлого, журам бий юу?	тийм
AF2		Буцаан татан авсан бараа бүтээгдэхүүн	Хүнсний чанар, аюулгүй байдлыг хангаагүй буцаагдсан эсвэл худалдах боломжгүй болсон бүтээгдэхүүний хувь	0.016% буюу 118'405'230 төг

